



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Сүхбаатар аймаг дахь төрийн
аудитын газар

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗӨВЛӨЛ НЬ ҮНДСЭН ЧИГ ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭЭГҮЙ,
ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ЖИГДРЭЭГҮЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БҮЙ
БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: СБА-2024/20-16-ШТА-ГА

Баруун-Урт 2024 он



Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Н.Болдбаатар

Утас: 70512127 Цахим хаяг: boldbaatarn@audit.gov.mn

Аудитор Э.Алтансүх

Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Аудитор Б.Ганццэг

Утас: 70512127 Цахим хаяг: gantsetsegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4
БҮЛЭГ А. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ДУНДЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БҮРДЭЭГҮЙ, МЭРГЭЖЛИЙН НИЙГМИЙН АЖИЛТАН, СЭТГЭЛ ЗҮЙЧ ДУТМАГ БАЙГАА НЬ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БАЙНА.	5
1.1. Хүүхэд хамгааллын хууль, бодлого нь "Алсын хараа-2050"-тай нийцдэг ч хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрүүд хүлээн авагчдын онцлогт тохироогүй байна.	5
1.2. Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны дундын мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй, мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч дутмаг байна. ..	6
БҮЛЭГ Б. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНД ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТӨСВИЙН 16.9 ХУВИЙГ ЗАРЦУУЛЖ, МӨН ЭРСДЭЛТ НӨХЦӨЛД БАЙГАА ХҮҮХДИЙГ ДУТУУ БҮРТГЭСНЭЭС ШАЛТГААЛАН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНД БҮРЭН ХАМРУУЛААГҮЙ БАЙНА.....	9
2.1. Хүчирхийлэлд өртсөн 315 хүүхдийн 97.5 хувь нь гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн боловч хүүхэд хамгааллын төсвийн зөвхөн 16.9 хувийг гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулжээ.....	9
2.2. Хүүхэд хамгааллын зардлын 3.1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, эрсдэлт хүүхдүүдийг дутуу бүртгэснээс шалтгаалан урьдчилан сэргийлэх үйлчилгээнд бүрэн хамруулаагүй.	11
БҮЛЭГ В. ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗӨВЛӨЛ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХАД АНХААРАХ ШААРДЛАГАТАЙ, МӨН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН 80-ИАС ДЭЭШ ХУВИЙГ 108 УТСАНД МЭДЭЭЛЭЭГҮЙ БАЙНА.....	16
3.1. Хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавихад чиглэсэн арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.	16
3.2. Гэр бүлийн орчинд архидалтаас болж хүүхэд ихээр хүчирхийлэлд өртсөн, БШУГ болон ХГБХХГ хооронд мэдээлэл солилцоо хангалтгүй, АНЭ гадны шалтгаант бэртэл, гэмтлийг 108 утсанд мэдээлдэггүй, мориноос унасан хүүхдүүдэд урьдчилан сэргийлэхээс бусад үйлчилгээг кейс нээлгүйгээр үзүүлжээ.....	20
3.3. Хүчирхийлэлд өртсөн 387 хүүхдийн 87.6 хувь буюу 339 хүүхдийн мэдээллийг 108 утсанд бүртгүүлээгүй байна.....	25
Холбогдох байгууллагын санал:	32
Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:	33
ДҮГНЭЛТ: 33	
ЗӨВЛӨМЖ:.....	33

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АНЭ	Аймгийн нэгдсэн эмнэлэг
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ГССҮТ	Гэмтэл, согог судлалын үндэсний төв
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн газар
МҮОНТ	Монголын үндэсний олон нийтийн телевиз
НДГ	Нийгмийн даатгалын газар
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ОБГ	Онцгой байдлын газар
ТББ	Төрийн бус байгууллага
ХГБХХГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын зарцуулалт 2023 он	17
Хүснэгт 2	Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага мэдээллийн шийдвэрлэлт 2023 он	27

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл		
Аудит үндэслэл, эрх	хийх бүрэн	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоолыг үндэслэн гүйцэтгэв.
Аудитын зорилт		Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт болон бий болсон үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан Улсын Их Хурлын байнгын хороо, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго оршино.
Аудитын хүрээ	хамарсан	Аудитад Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд хүүхэд хамгааллын чиглэлээр, үйл ажиллагаанд оролцдог төрийн болон төрийн бус байгууллагуудын 2019-2023 оны баримт, мэдээллийг хамруулан аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт		Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа авах арга зүйг ашиглаж аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа		Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Г.Даваа удирдаж, аудитын менежер М.Нарантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Болдбаатар, аудитор Э.Алтансүх, Б.Ганцэцэг нар 2024 оны 08 сарын 12-ны өдрөөс 10 сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд аудитыг гүйцэтгэв.

БҮЛЭГ А. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ДУНДЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БҮРДЭЭГҮЙ, МЭРГЭЖЛИЙН НИЙГМИЙН АЖИЛТАН, СЭТГЭЛ ЗҮЙЧ ДУТМАГ БАЙГАА НЬ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БАЙНА.

1.1. Хүүхэд хамгааллын хууль, бодлого нь "Алсын хараа-2050"-тай нийцдэг ч хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрүүд хүлээн авагчдын онцлогт тохироогүй байна.

1.1.4 Хүүхэд хамгааллын тухай хууль нь “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичигтэй хүүхдийн эрх, хамгаалал, тэгш хүртээмжийг хангах чиглэлээр нийцэж байна.

1.1.4.1. “Алсын хараа-2050” болон Хүүхэд хамгааллын хууль тогтоомжуудын уялдааг авч үзэхэд дараах үндсэн чиглэлүүдэд нийцэж байна:

- **Ядуу болон эмзэг бүлгийн хүүхдүүдийг хамгаалах:** “Алсын хараа-2050”-д ядуу, эмзэг бүлгийн хүүхдүүдэд тэгш боломж олгох, тэдний боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд тэгш нэвтрэх талаар онцолсон. Энэ нь Хүүхэд хамгааллын хуулийн эмзэг бүлгийн хүүхдүүдэд үзүүлэх хамгаалалт, нийгмийн үйлчилгээний зохицуулалттай уялдаж байна.
- **Боловсролын орчинд хүүхдийг хүчирхийллээс хамгаалах:** “Алсын хараа-2050” нь боловсролын тэгш хүртээмж, сургуульд хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгыг агуулдаг. Хүүхэд хамгааллын хуульд мөн адил сургуулийн орчинд хүүхдийг хамгаалах заалтууд орсон нь бодлогын хувьд нийцэж байна.
- **Гэр бүлийн орчин дахь хамгаалал:** Хүүхэд хамгааллын хуульд гэр бүлийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тодорхой зохицуулалтууд бий. “Алсын хараа-2050” нь гэр бүлийн орчинд хүүхдийн сайн сайхныг дэмжих зорилттой тул бодлогын хувьд нэгдсэн зорилготой байна.
- **Эрүүл мэндийн үйлчилгээний тэгш хүртээмж:** Хүүхдийн эрүүл мэндийн тусламж, хамгаалалтыг сайжруулах зорилго нь “Алсын хараа-2050”-д ч, Хүүхэд хамгааллын хуульд ч тодорхой тусгагдсан нь эрүүл мэндийн үйлчилгээний салбарт хүүхдийн хамгааллыг сайжруулахад нийцэж байна.

1.1.4.2. “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний 9 бүлгийн 73 шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй байна. Эдгээр шалгуур үзүүлэлтийг авч үзэхэд “Хүний хөгжил” бүлэгт боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаантай холбоотой 17 үзүүлэлт; “Амьдралын чанар ба дундаж давхарга” бүлэгт ядуурлын түвшин, ажилгүйдлийн түвшин, бизнес эрхлэлтийн үзүүлэлт, инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь гэх мэт 10 үзүүлэлт тус тус багтсан байна.

1.1.4.3. Мөн “Засаглал” бүлэг дэх хуулийн засаглал гэсэн үзүүлэлт нь нийгмийн дүрэм журмыг сахих итгэл үнэмшлийн хэр хэмжээ, гэрээний хэрэгжилт, өмчлөх эрх, цагдаа болон шүүхийн чанар, гэмт хэрэг, хүчирхийлэл гарах магадлал зэргийг хэмждэг байна.

1.1.4.4. Иймд Хүүхэд хамгааллын тухай хууль болон “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгүүд хүүхдийн хамгаалал, тэгш боломж, аюулгүй байдал, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг гол асуудлуудад ижилхэн анхаарал хандуулж, нэг зорилгыг чиглэсэн зохицуулалтаараа хоорондоо уялдаж байна.

1.1.6. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн агуулга, бүтэц, шалгуур үзүүлэлтүүд тухайн хөтөлбөрийн хүлээн авагчдын онцлогт тохирсон байдлаар боловсруулагдаагүй байна.

1.1.6.1. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдийн хүлээн авагчдын онцлог нь тэдгээрийн амьдралын нөхцөл байдал, эрсдэл, нийгмийн бүлгийн онцлог, насны ялгаа зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг.

1.1.6.2. Тодруулбал гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд, ядуу, эмзэг бүлгийн хүүхдүүд, өрх толгойлсон эсвэл хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эхтэй хүүхдүүд, сургууль завсардсан хүүхдүүд, сургуулийн орчинд дарамт, хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд, хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд: хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, алслагдсан сум, орон нутгийн хүүхдүүд нь харилцан ялгаатай байдлаар хамгааллын болон урьдчилан сэргийлэх үйлчилгээ авах хэрэгцээтэй байдаг.

1.1.6.3. Засгийн газрын тогтоолоор 2002 онд батлагдсан “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр” болон Засгийн газрын тогтоолоор 2017 онд батлагдсан “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-үүдийн агуулгын ангилал, шалгуур үзүүлэлтийн бүлэглэсэн байдлыг авч үзэхэд хөтөлбөрийн хүлээн авагчдад суурилсан бус ерөнхий ангилалтай байна. Тухайлбал 2002 оны хөтөлбөрт хүүхдийн амьдралын эрүүл, аюулгүй орчин, хүүхдийн чанартай боловсрол, төлөвшил, гэр бүлд түшиглэсэн хүүхэд хамгаалал, хүүхэд өсвөр үеийнхний оролцоо, мэдээллийн хүртээмж гэх мэтээр бүлэглэж хөтөлбөрийн агуулгыг тодорхойлж, арга хэмжээг төлөвлөсөн байна. Энэ нь амьдралын нөхцөл байдал, нийгмийн бүлгийн онцлог, насны ялгаа, хүчирхийллийн ямар хэлбэрт өртсөн, ямар эрсдэлт нөхцөлд байгаа зэргээс шалтгаалсан хамгааллын үйлчилгээний хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байхад нөлөөлж байна.

1.1.6.4. Иймд хүүхэд хамгааллын үндэсний хөтөлбөрийг сайжруулахдаа хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхдүүдийн онцлогт нийцсэн агуулга, бүтэц, шалгуур үзүүлэлтүүдийг бүлэглэж боловсруулах нь хөтөлбөрийн үр нөлөөг нэмэгдүүлж, хүүхдэд үзүүлэх тусламжийн чанарыг сайжруулах ач холбогдолтой байна.

1.2. Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны дундын мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй, мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч дутмаг байна.

1.2.2. Хүчирхийлэлд өртсөн бүх хүүхдийн мэдээллийг 108 утсанд бүрэн мэдээлүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх тухай бүрд кейс нээж байх шаардлагатай байна.

1.2.2.1. Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор “Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг”, “Байгууллагад эцэг эхийн зөвлөл байгуулж ажиллах зөвлөмж”-ийг тус тус баталсан бөгөөд энэхүү баримт бичиг нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх байгууллагууд, хуулийн этгээдэд хамаарна. 2023 оны жилийн эцсийн байдлаар Сүхбаатар аймагт нийт 829 хуулийн этгээд бүртгэлтэй байна. Эдгээрийн дотроос 72 байгууллага буюу 8.7% нь хүүхэд хамгааллын бодлоготой, 102 байгууллага буюу 12.3% нь эцэг эхийн зөвлөлтэй, 68 байгууллага буюу 8.2% нь хүүхдийн өрөөтэй болжээ.

1.2.2.2. Сүхбаатар аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь хүүхэд хамгааллын үйл ажиллагааны статистик тоо, мэдээг батлагдсан маягтын дагуу бүрэн гаргаж, хадгаламжийн нэгж болгон архивлах, мөн нөхцөл байдлын үнэлгээ, хувийн хэргийн хадгаламжийн нэгжид товьёг хийж, эмх цэгцтэй архивлаж байх шаардлагатай байна.

1.2.2.3. Мэдээллийн санд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн бүрэн бүртгэх, хурдан мориноос унасан хүүхдүүд болон хүчирхийлэлд өртсөн бүх хүүхдийн мэдээллийг хүүхдийн тусламжийн 108 утсанд бүрэн мэдээлүүлэх, мэдээлсэн эсэхэд хяналт тавих. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагаас яаралтай тусламжийн үйлчилгээ авсан хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй хүүхдийн мэдээллийг 108 утсанд мэдээлсэн эсэхэд хяналт тогтмол хугацаанд тавьж ажиллах, мөн цаашид хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх тухай бүрд кейс нээж байх шаардлагатай байна.

1.2.2.4. Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвөөс гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулж буй хувь хэмжээг цаашид нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын төсвийг зориулалт бус зарцуулахгүй байх зэрэгт анхаарах шаардлагатай байна.

1.2.5 Хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд оролцогч талуудын дундын мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй байна.

1.2.5.1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2022 онд Нийслэл, 9 дүүрэг, 21 аймгийн 718 хамтарсан багийн 1436 ахлагч болон нийгмийн ажилтнуудад “Нийгмийн ажилтны мэдээллийн сан” системийг хэрэглээнд нэвтрүүлэх цахим сургалтыг зохион байгуулжээ.

1.2.5.2. Энэхүү систем нь Хамтарсан баг гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн хохирогчийн мэдээлэл хүлээн авах, бүртгэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчилгээ үзүүлэх, дүгнэлт гаргах үйл ажиллагааг цахимжуулж, нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэн системийн хэрэглэгчид тайлан мэдээллийг цаг алдалгүй харж, бодлого төлөвлөлт, төсөвлөлт хийх боломжийг бүрдүүлэх зорилготой байна.

1.2.5.3. “Нийгмийн ажилтны мэдээллийн сан” системийн хувьд 2023 оноос хөгжүүлэгч компани болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас тус системд нэвтрэх эрхгүй болгож, хаасан байна. Цаашид уг системийг ашиглах эсэх нь тодорхойгүй байна.

1.2.5.4. Монгол Улсад үндэсний хэмжээнд нэг утас ажиллаж байгаа бөгөөд Хүүхдийн тусламжийн 108 утас нь 24 цагийн турш үнэ төлбөргүйгээр Монгол улсын өнцөг булан бүрээс 0-18 насны хүүхдийн хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийн эрхийн зөрчлийн тухай мэдээлэл хүлээн авдаг байна.

1.2.5.5. Хүүхдийн тусламжийн 108 утас нь дуудлага мэдээллийг орон нутгийн ХГБХХГ-т хүргэснээр яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээнд холбон зуучлах, нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хүүхдийн эрхийг хангах нөхцөл бүрддэг байна. Мөн тус утас нь хүүхдийн дуу хоолойг сонсон хүүхэд хамгааллын асуудлаар шийдвэр гаргахад болон хүүхэд хамгаалалд хүүхдийн оролцоог хангах, оролцоонд тулгуурлан хүүхдийг хөгжүүлэх, эрсдэлээс

хамгаалах, урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалалд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулдаг байна.

1.2.5.6. Хүүхдийн тусламжийн 108 утасны бүртгэл, мэдээллийн системд улсын хэмжээний хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийн эрхийн зөрчлийн гомдол, мэдээлэл бүртгэгдэж, мэдээллийн сан үүсдэг байна.

1.2.5.7. Хүүхэд хамгаалалтай холбоотой үйл ажиллагаа явуулдаг БШУГ, ЭМГ, АНЭ, Шүүхийн тамгын газар, Прокурорын газар, ШШГГ, Цагдаагийн газар, ЗДТГ, ХХҮГ, НДГ, ОБГ, ХГБХХГ зэрэг байгууллагуудын хүүхэд хамгааллын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл төвлөрдөг нэгдсэн системгүй байна.

1.2.5.8. Эдгээр байгууллагууд нь өөрсдийн үндсэн үйл ажиллагааны бүртгэл мэдээллийн системээс хүүхэд хамгаалалтай холбоотой мэдээллийг шаардлагатай үед албан бичгээр солилцох байдлаар хамтран ажилладаг. Өөрөөр хэлбэл, хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд оролцогч талуудын дундын мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй байна.

1.2.6 Хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллах мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч мэргэжилтэй боловсон хүчин дутмаг байгаа нь хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, үр нөлөөг бууруулж, хүүхдийн аюулгүй байдлын асуудалд сөрөг нөлөө үзүүлэх үр дагавартай байна.

1.2.6.1. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь 2019-2021 онд 20 орон тоо батлагдсанаас бүрэн, 2022-2023 онд 21 орон тоо батлагдсанаас 19 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна. Тодруулбал хүүхдийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, нийгмийн ажилтан гэсэн орон тоонд мэргэжлийн шаардлага хангах боловсон хүчин дутагдалтайгаас 2 орон тоо дутуу ажилласан байна.

1.2.6.2. Түр хамгаалах байр нь өдрийн нийгмийн ажилтан-1, сэтгэл зүйч-1, ээлжийн халамжийн ажилтан-4, тогооч-1, нийт 7 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна.

1.2.6.3. Сүхбаатар аймгийн 13 суманд тус бүр нэг хамтарсан баг буюу нийт 13 баг ажиллах ёстой боловч Баруун-Урт сумын 9 багт нэмэлт хамтарсан багууд байгуулснаар аймгийн хэмжээнд нийт 22 хамтарсан баг үйл ажиллагаа явуулж, эдгээр багт 150 төрийн албан хаагч ажиллаж байна.

1.2.6.4. Хамтарсан багийн бүрэлдэхүүнд багийн Засаг дарга, сумын нийгмийн бодлогын мэргэжилтэн, цагдаагийн албан хаагч, эмч, сургуулийн нийгмийн ажилтан, цэцэрлэгийн арга зүйч зэрэг албан хаагчид ордог бөгөөд тэд үндсэн ажлынхаа хажуугаар хамтарсан багийн үйл ажиллагааг гүйцэтгэдэг. Энэ нь тэднийг хамтарсан багийн хуралд оролцох боломжгүй болох, эсвэл хурлын үеэр бие биеэ хүлээн цаг алдах зэрэг асуудлыг үүсгэдэг. Үүний улмаас багийн ажлын зохион байгуулалт алдагдаж, хүүхэд хамгааллын асуудлыг шийдвэрлэх үйл явц удааширдаг байна.

1.2.6.5. Мөн хамтарсан багийн бүрэлдэхүүний нэг болох цагдаагийн албан хаагч шилжих болон дэвших үед дараагийн хүнийг томилох хүртэлх хугацаанд, өөр хамтарсан багийн гишүүн буюу цагдаагийн албан хаагчийг гуйж хамтран ажиллах шаардлагатай болдог. Эдгээр хүчин зүйл нь хамтарсан багийн ажлын үр дүнд нөлөөлж болзошгүй бөгөөд үйл ажиллагааг тасалдуулахгүй байхын тулд илүү уян хатан, зохион байгуулалттай байх шаардлагатай байна.

1.2.6.6. Сүхбаатар аймгийн боловсролын салбарт 21 нийгмийн ажилтан ажиллаж байгаагаас 16 нь нийгмийн ажилтан мэргэжилтэй, бусад нь багш мэргэжилтэй байна. Мөн ерөнхий боловсролын сургуулиудад нийт 7 сэтгэл зүйч ажиллаж байгаагаас 5 нь “Боловсролын сэтгэл зүйчийн 45 хоногийн сургалт”-д хамрагдсан, 2 нь хамрагдаагүй байна.

1.2.6.7. Мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн орон тоо хангалтгүй, энэ чиглэлээр мэргэжилтэй боловсон хүчин дутмаг байгаагаас хүүхэд хамгааллын үйлчилгээний хүртээмж, чанар алдагдахад хүрч байна. Иймд улс, орон нутгаас нийгмийн хамгааллын салбарт ажиллах боловсон хүчнийг бэлтгэх, залууст дэмжлэг үзүүлэх бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тэтгэлэг, хөнгөлөлт, урамшуулал зэрэг арга хэмжээг хэрэгжүүлснээр шаардлагатай мэргэжилтнүүдийн орон тоог бүрдүүлж, үйлчилгээний үр нөлөөг сайжруулах боломжтой гэж үзэж байна.

БҮЛЭГ Б. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНД ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТӨСВИЙН 16.9 ХУВИЙГ ЗАРЦУУЛЖ, МӨН ЭРСДЭЛТ НӨХЦӨЛД БАЙГАА ХҮҮХДИЙГ ДУТУУ БҮРТГЭСНЭЭС ШАЛТГААЛАН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНД БҮРЭН ХАМРУУЛААГҮЙ БАЙНА.

2.1. Хүчирхийлэлд өртсөн 315 хүүхдийн 97.5 хувь нь гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн боловч хүүхэд хамгааллын төсвийн зөвхөн 16.9 хувийг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулжээ.

2.1.1. Хүүхэд хамгаалалд зориулсан төсөв, зардлыг норматив, аргачлалын дагуу төлөвлөсөн байна.

2.1.1.1. Хүүхэд хамгаалалд зориулсан төсвийг төлөвлөхдөө Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, 27 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив, аргачлал”-ыг баримталдаг байна.

2.1.1.2. “Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив, аргачлал” болон тус аргачлалыг хэрэгжүүлэх зөвлөмжид хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх дундаж хугацааг бэлгийн хүчирхийллийн хувьд 180 хоног, бие махбодын хүчирхийлэл болон сэтгэл санааны хүчирхийлэлд 49 хоног, үл хайхрах хүчирхийлэлд 14 хоног байхаар заасан байна.

2.1.1.3. Төсвийн төслийг боловсруулах дээрх аргачлал, зөвлөмжийн дагуу өмнөх жилийн статистик тоо мэдээний үйлчилгээ авсан хүүхдийн тоог хүчирхийллийн төрөл тус бүрд үйлчилгээ үзүүлэх дундаж хугацаагаар зардлыг тооцоолдог байна. Харин “гэр бүлийн хөгжил, хамгаалал” арга хэмжээ, “залуучууд болон оюутнууд” арга хэмжээнүүд нь зардлын нормативгүй байна.

2.1.1.4. Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр хийгдэх ажлын 2023 оны зардлыг 181.8 сая төгрөгөөр төсвийн төсөлд тусгаж, 179.3 сая төгрөгөөр батлагдсан, гэр бүлийн хөгжил, хамгааллын арга хэмжээний зардал 7.2 сая төгрөгөөр, залуучууд болон оюутнууд арга хэмжээнд 16.7 сая төгрөг байна.

2.1.2 Хүчирхийлэлд өртсөн 315 хүүхдийн 97.5 хувь гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн байхад хүүхэд хамгааллын төсвийн 16.9 хувийг гэр бүлийн орчны хүчирхийллийг бууруулах арга хэмжээнд зарцуулсан байна.

2.1.2.1. ХГБХХГ-ын 2023 оны батлагдсан төсвөөс үзэхэд хүүхэд хамгааллын төсөв нь 179.3 сая төгрөг, үүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал 56.0 сая төгрөг байна. Өөрөөр хэлбэл хүүхэд хамгааллын төсвийн 31.2 хувийг урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд зарцуулж байна. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас хөгжил, оролцооны үйл ажиллагааг түлхүү санхүүжүүлж байна. Тухайлбал 2023 онд урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд батлагдсан 56.0 сая төгрөгөөс 38.0 сая төгрөг буюу 67.8 хувийг хөгжил, оролцооны үйл ажиллагаанд зарцуулсан байна.

2.1.2.2. Мөн хамгаалал, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 13.8 сая төгрөгийг хөгжил, оролцооны үйл ажиллагаанд, 36.7 сая төгрөгийг эрсдэлт нөхцөлөөс урьдчилсан сэргийлэх үйл ажиллагаанд тус тус нэмэлтээр зарцуулсан байна. Тодруулбал 2023 онд хүүхэд хамгааллын төсвийн 59.4 хувь буюу 106.5 сая төгрөгийг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулсан байна.

2.1.2.3. Хүүхэд хамгааллын төсвийн хөрөнгө нь хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулахад чиглэж байгаа эсэхийг судлахад, Сүхбаатар аймагт 2023 онд 315 хүүхэд хүчирхийлэлд өртсөн мэдээлэл гарчээ. Үүнээс 307 хүүхэд буюу 97.5 хувь нь гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн байна. Гэр бүлийн хүчирхийллийг ихэвчлэн насанд хүрэгчид үйлддэг бөгөөд архи, согтууруулах ундаа хэрэглэсэн үед энэ асуудал хурцаар илэрдэг. 2019-2023 онд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 35 удаагийн сургалт, нөлөөллийн ажил, арга хэмжээг зохион байгуулахад 58.6 сая төгрөгийн зарцуулсан байна.

2.1.2.4. ХГБХХГ-ын 2023 онд гэр бүлийн хүчирхийлэл болон согтууруулах ундааны зохисгүй хэрэглээг бууруулахад чиглэсэн 18 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Гэр бүлийн хөгжил, хамгааллын арга хэмжээ, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс гэр бүлийн хүчирхийллийг бууруулахад чиглэсэн дээрх 18 арга хэмжээнд 22.6 сая төгрөг зарцуулсан нь Хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд зарцуулсан 106.5 сая төгрөгтэй харьцуулахад 16.9 хувийг эзэлж байна.

2.1.2.5. Өөрөөр хэлбэл гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн хүүхэд нь нийт хүчирхийлэлд өртсөн хүүхдийн 97.5 хувь байхад, гэр бүлийн хүчирхийллийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааны зарцуулалт нь хүүхэд хамгааллын төсвийн 16.9 хувийг эзэлж байна. Иймээс хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулахын тулд гэр бүлийн орчин дахь хүчирхийллийг таслан зогсоох чиглэлээр илүүтэй хөрөнгө, нөөцөө хуваарилах шаардлагатай байна.

2.1.3 Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 118.5 сая төгрөгийн төсвөөс 2023 онд 48 кейсийн хариу үйлчилгээнд нийт 9.9 сая төгрөг зарцуулж, үлдсэн төсвийг хүүхдийн хөгжил-оролцоо, урьдчилан сэргийлэх болон бусад хамгааллын үйл ажиллагаанд зарцуулсан байна.

2.1.3.1. Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай нөөцийг авч үзэхэд Сүхбаатар аймгийн ХГБХХГ-ын 2023 оны төсөвт эрсдэлийн

болон нөхцөл байдлын үнэлгээ хийх арга хэмжээний зардал/шуурхай тусламжийн үйлчилгээ/-д 4.7 сая төгрөг, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 118.5 сая төгрөг, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 56.0 сая төгрөг тус тус батлагдаж, зарцуулсан байна.

2.1.3.2. Эдгээр арга хэмжээний зардлын бодит гүйцэтгэлийг норматив, хөрөнгө зарцуулах тушаал шийдвэр зэрэгт үндэслэн дүн шинжилгээ хийж үзлээ. Шуурхай тусламжийн үйлчилгээний зардлын норматив нь 1 кейсэд 43.5 мянган төгрөг бөгөөд 2023 оны 48 кэйсийн зардал нь 2.1 сая төгрөг байна. Гүйцэтгэлээр 4.7 сая төгрөг зарцуулсан шалтгааныг авч үзэхэд 2.6 сая төгрөгөөр эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг даатгалд хамруулсан байна.

2.1.3.3. Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын зарцуулалтыг авч үзэхэд 48 кейстэй холбоотой зардал хамгаалах, хариу үйлчилгээний зардал нь 9.9 сая төгрөг байна. Энэ нь Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх дундаж хугацаа /14, 49, 182 хоног/-наас харьцангуй цөөн хоног буюу ихэнхдээ 7 хоногийн үйлчилгээ үзүүлдэгтэй холбоотой байна.

2.1.3.4. Үүнтэй холбоотойгоор гэр бүлээс тусдаа орчин дахь хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардлын хэмнэлт бий болж, хэмнэгдсэн зардлыг эрсдэлт нөхцөлд байгаа болон өмнө нь хүчирхийлэлд өртөж байсан хүүхдүүдийн гэрийн эргэлт хийх, хүүхэд хамгааллын багц олгох, урьдчилан сэргийлэх, хөгжил оролцоо зэрэг үйл ажиллагаанд зарцуулдаг байна.

2.2. Хүүхэд хамгааллын зардлын 3.1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, эрсдэлт хүүхдүүдийг дутуу бүртгэснээс шалтгаалан урьдчилан сэргийлэх үйлчилгээнд бүрэн хамруулаагүй.

2.2.1 Хамгаалах, нөхөн сэргээх болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас 3.1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

2.2.1.1. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь хамгаалах, нөхөн сэргээх болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг зориулалт бусаар зарцуулсан дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- 2023 оны 5 дугаар сарын 31-нд хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас байгууллагын албан хаагчдын хүүхдүүдийн дархлаажуулалтыг дэмжихэд 1,020.0 мянган төгрөгийг,
- 2023 оны 9 дүгээр сарын 18-нд сургууль, цэцэрлэгт шинээр элсэн орж буй албан хаагчдын хүүхдүүдэд хичээлийн шинэ жилийн дэмжлэг үзүүлэхэд урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас 420.0 мянган төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан байна.

2.2.1.2. Харин Сүхбаатар аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2023 онд ХГБХХГ-ын 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалттай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр болон хүүхэд хамгааллын зардлын нийт 248.5 сая төгрөгийн төсвөөс "Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив"-ын дагуу 45.6 хувийг зарцуулж, үлдсэн 54.4 хувийн зарцуулалт нь ямар нэгэн журмын зохицуулалтгүй зардал байна.

- Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас байгууллагын ажилтан, албан хаагчдын хүүхдүүдийн гарын бэлэгт 629.4 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.
- Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас ажилчдын хүүхдүүдийн дархлаажуулалтад 1,020.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

2.2.1.3. Төрийн аудитын байгууллагаас хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгээр 2021 онд "ЗГ-ын тогтоолтой холбоотой хэмнэлтийн горим хэрэгжүүлээгүй 15.2 сая төгрөгийн зөрчил"-д, 2023 онд "Цалингийн сангийн хэмнэлтийг ахмадын сангийн дансанд төвлөрүүлж, төсвийн хэмнэлтийг зориулалт бусаар зарцуулсан 17.4 сая төгрөгийн зөрчил"-д албан шаардлага хүргүүлж, 2022 онд "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчдэд цалин зөрүүтэй бодсон 84.3 мянган төгрөгийн зөрчил"-д зөвлөмж өгсөн. Эдгээр 2 албан шаардлага, 1 зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2.2.2. Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтыг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлж ажилласан байна.

2.2.2.1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

2.2.2.2. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг 2019-2023 оныг хамруулан шалгалаа. Тухайлбал 2023 оны байдлаар шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 30 гүйлгээний 684.6 сая төгрөг, зарлагын 3 гүйлгээний 38.5 сая төгрөгийг мэдээллийг байршуулж бүрэн мэдээлсэн байна.

2.2.2.3. Мөн хуулийн 6.4.8-т заасан төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 209 шийдвэрийг шилэн дансны цахим системд мэдээлж, эрх зүйн актын хэрэгжилтийг хангасан байна. 2019-2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд зөрчил илрээгүй байна.

2.2.3 Хүүхэд хамгааллын талаар Олон улсын байгууллагаас санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд ажлын хэсэг байгуулан хяналт хийж хэвшээгүй байна.

2.2.3.1. Олон улсын байгууллагаас 2019-2020 онуудад зээл, тусламжийн санхүүжилт авч байгаагүй, 2021, 2022, 2023 онуудад Японы Хүүхдийг ивээх сан, Азийн хөгжлийн банк, НҮБ-ын Хүн амын сангаас 3 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- 2019 онд "Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл"-ийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хэрэгжүүлж, Азийн хөгжлийн банк, Японы хүүхдийг ивээх сан санхүүжүүлэгч байгууллагаар ажиллажээ.
- 2022 онд Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банк хамтран "Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл"-тэй тэмцэх төслийн

хүрээнд “Түр хамгаалах байр”-ыг байгуулж, төслийн хэрэгжүүлэгчээр аймгийн Цагдаагийн газар ажилласан байна.

- 2023 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр “Залуучуудын хөгжлийн төв”-ийг Мөнххаан суманд байгуулж 03 дугаар сарын 24-ны өдөр хүлээлгэн өгчээ.

2.2.3.2. Сүхбаатар аймаг олон улсын байгууллагуудын зээл, тусламжид бага хамрагддаг. Олон улсын байгууллагуудаас зээл, тусламж авахын тулд тодорхой зорилго, зорилтот бүлэг, үр дүн, санхүүжилтийн тооцооллыг нарийвчлан багтаасан, шаардлага, шалгуурыг хангасан төсөл боловсруулах шаардлагатай. Мөн, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, төслийн санхүүжилт болон тусламж авах боломжуудыг судлах нь чухал юм. Ийм арга хэмжээг авч хэрэгжүүлснээр аймгийн хөгжлийн төсөл, хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, нийгмийн үйлчилгээ, хүүхэд, гэр бүлийн хамгааллын чиглэлээр шаардлагатай санхүүжилтийг төвлөрүүлэх боломжтой болно.

2.2.4. Мэдээллийн санд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг дутуу бүртгэсний улмаас урьдчилан сэргийлэх үйлчилгээнд зорилтот бүлгийн хүүхдүүдийг бүрэн хамруулаагүй байна.

2.2.4.1. Хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд оролцогч талууд шуурхай тусламжийн үйлчилгээ буюу нөхцөл байдлын үнэлгээ, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үйлчилгээ гэсэн 3 үндсэн төрлөөр үйлчилгээ үзүүлдэг байна.

2.2.4.2. Сүхбаатар аймаг 2023 оны жилийн эцсийн байдлаар 25,290 хүүхэдтэй байгаа бөгөөд урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлэхийн тулд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн мэдээллийг бүртгэдэг байна. Харин эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн бүртгэлийн программд 1046 хүүхэд бүртгэлтэйгээс өндөр эрсдэлтэй 350, дунд эрсдэлтэй 380, бага эрсдэлтэй 150, эрсдэлгүй 166 хүүхэд байна.

2.2.4.3. Дээрх мэдээллийн санд бүртгэлтэй хүүхдүүдийг сумаар нь авч үзэхэд Баруун-Урт сум 240, Түвшинширээ сум 111, Уулбаян сум 150 хүүхэд, Онгон сум 17, Сүхбаатар сум 18 хүүхэд гэх зэргээр харилцан адилгүй, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо эрс ялгаатай байна.

2.2.4.4. Мөн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээллээс авч үзэхэд 39 бүтэн өнчин хүүхдийн 23 хүүхэд нь, 552 хагас өнчин хүүхдийн 434 хүүхэд нь, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан өрхийн 562 хүүхдийн 476 нь эрсдэлийн программд огт бүртгэлгүй байна. Өөрөөр хэлбэл зөвхөн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээллээс үзэхэд 933 хүүхэд эрсдэлийн программын бүртгэлээс гадуур байна. Түүнчлэн уралдаанч хүүхдийн бүртгэлийн программд 903 хүүхэд бүртгэлтэй боловч эрсдэлийн программд 797 хүүхэд эрсдэлийн программд бүртгэлгүй байна. Энэ нь урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлэхэд суурь болох мэдээллийн сан хангалтгүй байгааг харуулж байгаа бөгөөд энэ нь урьдчилан сэргийлэх үйлчилгээнд эрсдэлт нөхцөлд байгаа зарим хүүхэд огт хамрагдахгүй байх эрсдэлийг бий болгож байна.

2.2.4.5. Иймд ХГБХХГ нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас дээрх мэдээллийг, Нийгмийн даатгалын газраас тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч хүүхдийн мэдээлэл, БШУГ-аас сургууль завсардсан хүүхдийн мэдээлэл, ЭМГ-аас

өвчлөмтгий болон суурь өвчтэй хүүхдүүдийн мэдээлэл, Дотуур байр, МСҮТ, “Баян-Эрхт” шашны сургуулийн хүүхдүүдийн иж бүрэн мэдээллийг авч эрсдэлийн программд бүртгэж, дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг иж бүрэн мэдээллийн санд үндэслэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2.2.4.6. Шүүх, Прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын газар, Биеийн тамир спортын газар, Соёл урлагийн газар, МСҮТ Эрдэнэ Мандал хийдийн дэргэдэх “Баян-Эрхт” шашны сургууль, гэх мэт хүүхэдтэй холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд ХГБХХГ-т эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн мэдээллийг нууцлалын шаардлагын ханган хүргүүлж, тогтмол хугацаанд мэдээлэл солилцдог байх шаардлагатай байна.

2.2.4.7. Сүхбаатар аймгийн хэмжээнд 2023 онд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 267 хүүхдийн мэдээллийг 108 утсанд бүртгүүлээгүй нь шуурхай тусламж, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг иж бүрэн үзүүлсэн эсэхийг баталгаагүй болгож байна. Эдгээр хүүхдэд шаардлагатай үйлчилгээг үзүүлсэн ч кейс буюу хувийн хэрэг нээлгүйгээр үйлчилгээ үзүүлснээс шалтгаалан үйлчилгээний шат дараалал зөрчигдсөн байна.

2.2.4.8. Иймд, хүчирхийллийн дуудлага, мэдээлэл 108 утсанд бүртгэгдсэн тохиолдолд ХГБХХГ-ын дарга болон хүүхдийн улсын байцаагч нар цахимаар хяналт тавих боломжтой байдаг ч дээрх 267 хүүхдийн мэдээллийг 108 утсанд бүртгүүлэх ажлыг зохион байгуулаагүй, мөн 108 утасны мэдээллийн системээр хяналт тавиагүй нь үйлчилгээний үр дүнг бууруулж, хүүхдийн эрх, хамгааллыг хангах үйл ажиллагаанд сөрөг үр дагаврыг бий болгож байна.

2.2.5 Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүүхдийн хувь хүний нууцыг задруулсан зөрчил бүртгэгдээгүй байна.

2.2.5.1. НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцын үндсэн зарчим нь хүүхдийн хувийн нууцыг хамгаалах юм. Тус конвенцын 16-р зүйлд зааснаар хүүхдийн хувийн болон гэр бүлийн амьдрал, захидал харилцаа, нэр хүндэд халдахыг хориглодог. Энэ нь хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд хүүхдийн хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй задруулахгүй байх ёстой гэсэн утгатай.

2.2.5.2. UNICEF, Save the Children зэрэг олон улсын байгууллагууд хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах тусгай дүрэм, журамтай байдаг. Тэдгээр байгууллагууд мэдээлэл цуглуулах, хадгалах, түгээхдээ зөвшөөрөл авах, нэргүй болгох зэрэг арга хэмжээг авдаг. Монгол Улсын "Хүүхэд хамгааллын тухай хууль" болон "Хувь хүний нууцын тухай хууль"-д мөн хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах үүрэгтэйг заасан байдаг. Хүүхдийн талаарх мэдээллийг зөвхөн хууль ёсны үндэслэлтэй, тухайн хүүхэд болон түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлтэйгөөр цуглуулж, ашиглах ёстой.

2.2.5.3. Хэдийгээр хүүхэд хамгааллын асуудал хариуцсан байгууллага бусад салбарын, тухайлбал хяналт шалгалтын байгууллагад нууцын баталгаа гарган хүүхэдтэй холбоотой мэдээллийг гаргаж өгч байгаа ч, үйл ажиллагааны түвшинд хамтарсан баг, ХГБХХГ, түр хамгаалах байр, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч,

цагдаагийн байгууллага, эрүүл мэндийн байгууллага, багш, сурган хүмүүжүүлэгч зэрэг олон байгууллага, албан хаагчдаар дамжин хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг. Энэ нь хүүхдийн мэдээллийн нууцыг алдагдуулах, бусдад дамжуулах эрсдэлтэй байгааг харуулж байна.

2.2.5.4. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хоорондын мэдээллийн солилцооны тогтолцоо хангалтгүй, нууцлалыг хангах механизмууд нь сул байгаа. Өөрөөр хэлбэл, тухайн хүүхдийн мэдээлэлд хандах эрх бүхий албан хаагчдын тоо олон байснаас шалтгаалан нууц мэдээллийг алдах эрсдэл нэмэгддэг. Хүүхдийн мэдээллийн нууц алдагдах нь тухайн хүүхдийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж, цаашид тусламж, үйлчилгээ авахад сэтгэлзүйн саад тотгор болж, хүчирхийлэлд өртөх эрсдэл нэмэгдэж магадгүй. Иймээс, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хооронд мэдээллийг нууцлалтай, найдвартай байдлаар солилцох механизмыг сайжруулах шаардлагатай.

2.2.5.5. Зөрчлийн тухай хуулийн 6.27.3 дахь заалтад хүний эмзэг мэдээллийг хууль бусаар олж авах, боловсруулах, бусдад дамжуулах, задруулах нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол иргэнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж заасан байдаг. Харин 2019-2023 оны хооронд хүүхдийн хувь хүний нууцыг задруулсан зөрчил бүртгэгдээгүй байна.

2.2.6. Эрсдэлт нөхцөлд буй хүүхдүүд болон зорилтот өрхүүдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээг санхүүжүүлэх хэрэгцээтэй байхад урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас хөгжил-оролцооны арга хэмжээг түлхүү санхүүжүүлсэн байна.

2.2.6.1. Хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 2023 онд 118.5 сая төгрөг батлагдсанаас 9.9 сая төгрөгийг хүчирхийлэлд өртсөн 48 хүүхдийн кейсийн хариу үйлчилгээнд, 10.2 сая төгрөгийг насанд хүрэгчийн хамт гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 101 хүүхдийн хариу үйлчилгээнд тус тус зарцуулсан байна. Үлдсэн 98.4 сая төгрөгийг хүүхэд хамгааллын үйлчилгээ, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлд зарцуулжээ. Тухайлбал 75.0 сая төгрөгийн 15 ажил гүйлгээний утга, мөнгөн дүн, үйлчилгээний төрлийг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 1. Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын зарцуулалт 2023 он (төгрөг)

№	Тушаалын нэр	Мөнгөн дүн	Үйлчилгээний төрөл
1	Хамтарсан багийн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх тухай	11,000,000	Хамгааллын үйлчилгээ
2	Хамтарсан багийн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх тухай	11,000,000	Хамгааллын үйлчилгээ
3	Зуслангийн хөгжлийн хөтөлбөрт оролцох тухай	8,534,600	Хамгааллын үйлчилгээ
4	Уралдаанч хүүхдийн бүртгэлийн карт болон уншигч худалдан авах	6,930,000	Урьдчилсан сэргийлэх
5	Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг зохион байгуулах тухай	5,700,000	Хамгааллын үйлчилгээ
6	Уралдаанч хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах тухай	5,032,200	Хамгааллын үйлчилгээ
7	Уралдаанч хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах тухай	4,981,500	Хамгааллын үйлчилгээ
8	Бүтэн өнчин хүүхдэд нэг удаагийн дэмжлэг олгох тухай	3,960,000	Хамгааллын үйлчилгээ

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

9	Үер усны ослоос сэргийлэх арга хэмжээ авах тухай	3,327,540	Урьдчилсан сэргийлэх
10	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай	3,010,000	Хамгааллын үйлчилгээ
11	Эрсдэлийн түвшнийг тогтоох програмд бүртгэлтэй хүүхдүүд-д эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ хийх тухай	2,974,200	Хамгааллын үйлчилгээ
12	Сэтгэлзүйн зөвлөгөө үйлчилгээнд хамруулах тухай	2,500,000	Хамгааллын үйлчилгээ
13	Хүүхдүүдийг хөгжлийн хөтөлбөрт хамруулах тухай	2,280,000	Хамгааллын үйлчилгээ
14	Уралдаанч хүүхдийн уулзалт-хэлэлцүүлэг зохион байгуулах тухай	2,040,000	Урьдчилсан сэргийлэх
15	Хүүхдийн хөгжил хамгааллын дэмжих жилийн хүрээнд ХХ хамтын ажиллагааны кейс хэлэлцүүлэг, арга зүй солилцох	1,720,000	Урьдчилсан сэргийлэх
Нийт дүн		74,990,040	

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар

2.2.6.2. Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд дараах 2 шалтгаанаар хэмнэлт бий болж байна. Тодруулбал орон нутгийн төсвөөс түр хамгаалах байрны зардалд 2023 онд 90.0 сая төгрөг батлагдаж, сар бүр 7.5 сая төгрөгийн санхүүжилт авсан, мөн хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх дундаж хугацаа /14, 49, 182 хоног/-наас үүдэлтэй хэмнэлт бий болж байна. Тухайлбал хамгаалал, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 118.5 сая төгрөгийн төсвөөс 14.0 сая төгрөгийг эрсдэлт нөхцөлөөс урьдчилсан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулсан байна. Цаашид хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхдээ хүүхэд тус бүр дээр кейс нээж байх нь зүйтэй байна.

2.2.6.3. Мөн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 19 үйлүүлэгчид үзүүлэх хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээний зардалд 2.7 сая төгрөг зарцуулсан байна. Энэ нь гэр бүлийн хөгжил, хамгааллын арга хэмжээний зардал 2023 онд 7.2 сая батлагдсан бөгөөд хүрэлцэхгүй байгаатай холбоотой байна.

2.2.6.4. Харин 2023 онд урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 56.0 сая төгрөг батлагдсанаас, хүүхдийн хөгжил, оролцооны 51 үйл ажиллагаанд 14,500 хүүхдийг хамруулан 38.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, зорилтот бүлгийн иргэдэд нөлөөллийн сургалт хийх зэрэг үйл ажиллагаанд 18.0 сая төгрөг зарцуулжээ. Өөрөөр хэлбэл урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын 67.9 хувийг хөгжил, оролцоонд, 32.1 хувийг урьдчилан сэргийлэх бусад арга хэмжээнд зарцуулсан байна. Иймд урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас хөгжил-оролцооны арга хэмжээнд гэхээсээ илүү эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүд, зорилтот бүлгийн өрхөд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээг түлхүү санхүүжүүлэх шаардлагатай байна.

БҮЛЭГ В. ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗӨВЛӨЛ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХАД АНХААРАХ ШААРДЛАГАТАЙ, МӨН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН 80-ИАС ДЭЭШ ХУВИЙГ 108 УТСАНД МЭДЭЭЛЭЭГҮЙ БАЙНА.

3.1. Хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавихад чиглэсэн арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3.1.1. Хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх салбарын онцлогт нийцсэн шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлалгүй байна.

3.1.1.1. Хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан баг зэрэг оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэхэд чиглэгдсэн тодорхой нарийвчилсан шалгуур үзүүлэлт, аргачлалгүй байна. Үүний улмаас хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар буурах, хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа үр дүнгүй болох эрсдэлтэй байна.

3.1.1.2. Иймд хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж, дүгнэхэд чиглэсэн шалгуур үзүүлэлтүүдийг олон улсын сайн туршлагад тулгуурлан боловсруулж, нэвтрүүлэх хэрэгцээ үүссэн байна.

3.1.2 Хүүхэд хамгааллын хуулийн шинэчилсэн найруулгыг 2024 оны 9 сараас мөрдөж эхэлжээ.

3.1.2.1. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын тооцоо, судалгааг хийсний үндсэн дээр УИХ-аар тус хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 01 сарын 17 өдөр батлагдаж, 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн байна. Хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотойгоор холбогдох дүрэм, журам, заавар шинэчлэгдэх ажил хийгдэж байна.

3.1.3. Олон улсын Корам Интернейшнл байгууллагаас өгсөн кэйс менежменттэй холбоотой зөвлөмж хэрэгжсэн байна.

3.1.3.1. Их Британи Улсын Корам Интернейшнл байгууллага Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хууль хэрэгжилтийн үнэлгээг 2021 онд хийж, хууль эрх зүйн шинэчлэл, кэйс менежментийн хүргэлт, хүүхэд хамгааллын үйлчилгээг хөгжүүлэх, мэдээллийн баазын удирдлага, хяналт ба үнэлгээтэй холбоотой зөвлөмжүүдийг нэн тэргүүнд болон дунд хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай гэж тодорхойлсон байна.

3.1.3.2. Дээрх Корам Интернейшнл байгууллагаас өгсөн зөвлөмжүүдээс орон нутгийн ХГБХХГ-тай холбоотой “Хамтарсан багт шилжүүлсэн бүх кэйс дээр тодорхой нэг кэйс менежерийг томилж, тухайн кэйс менежер нь кэйс менежментийн үйл явцыг хянаж удирдах ажлыг хариуцах” гэсэн зөвлөмж өгсөн байна. Тус зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзэхэд кэйс тус бүрд кэйс менежер томилогддог бөгөөд ихэвчлэн сургуулиудын нийгмийн ажилтнууд кэйс менежментийн үйл явцыг хянаж удирдах ажлыг хариуцдаг байна. Дээрх зөвлөмж Сүхбаатар аймагт бүрэн хэрэгжсэн байна.

3.1.4 Хүүхэд хамгааллын чиглэлээр Олон улсын байгууллага, төрийн бус байгууллагаас хэрэгжүүлсэн, үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийн үр дүнг нэгтгэж тайлагнадаг байна.

3.1.4.1. Японы Хүүхдийг ивээх сан, Азийн хөгжлийн банк, НҮБ-ын Хүн амын сангаас 2021-2023 онуудад нийт 128.7 сая төгрөгийн санхүүжилтээр хүүхэд, гэр бүл,

эмэгтэйчүүдэд чиглэсэн 3 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн байна. Мөн 2019-2023 онд 18 ТББ-тай хамтран хүүхэд, гэр бүлд чиглэсэн 17 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

3.1.4.2. Хүүхэд хамгааллын чиглэлээр Олон улсын байгууллага, төрийн бус байгууллагаас хэрэгжүүлсэн, үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийн үр дүнг ХГБХХГ нь байгууллагын гүйцэтгэлийн тайланд нэгтгэж тайлагнасан байна.

3.1.5. Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд дээд шатны байгууллагаас болон дотооддоо хяналт-шинжилгээ үнэлгээг хийсэн байна.

3.1.5.1. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газраас 2019-2023 онд Сүхбаатар аймгийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдлыг авч үзэхэд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн А/96 тоот тушаалаар Сүхбаатар аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хэсэг ирж ажилласан байна.

3.1.5.2. Дээрх ажлын хэсэг нь Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаа; Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх, журмын хэрэгжилт, хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн дуудлагын шийдвэрлэлт, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлсэн хүүхэд хамгааллын үйлчилгээний хэрэгжилт, хүүхдийн эрхийн зөрчил шалган шийдвэрлэлт, хүүхдийн хөгжил, оролцооны чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хэрэгжилт, гамшиг онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, үр дүн гэсэн 8 чиглэлээр зөвлөмж өгсөн байна.

3.1.5.3. ХГБХХГ-ын бүтэц, орон тоонд 2020 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтний орон тоо шинээр батлагдсан бөгөөд 2020-2023 онд хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэнтэй ажилласан байна. Тус мэргэжилтэн нь ХГБХХГ-ын 2022 оны бодлогын баримт бичиг, гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтэд хяналт шинжилгээ хийж, 6 зөвлөмж өгчээ. Мөн 2023 онд Түр хамгаалах байрны үйлчилгээ, үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж 15 зөвлөмж өгч ажилласан байна.

3.1.6. Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалгүй байгаа нь Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

3.1.6.1. Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалгүй байгаа нь Хүүхдийн төлөө зөвлөл үндсэн чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна.

3.1.6.2. Тодруулбал Хүүхдийн төлөө зөвлөл нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 21.1-д заасны дагуу хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй боловч бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх бодитой шалгуур үзүүлэлт, аргачлал байхгүйгээс үүдэн энэ үүргийн хэрэгжилт хангалтгүй байх, чиг үүрэгт хамааралгүй арга хэмжээ төлөвлөхөд хүргэж байна.

3.1.7 Сүхбаатар аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд анхаарал хандуулах шаардлагатай байна.

3.1.7.1. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр, Хүүхдийн эрхийн тухай конвенц зэрэг нь Монгол Улсын хүүхэд хамгааллын бодлого, хэрэгжилтийн үндэс болж, төрийн байгууллагууд, нийгмийн ажилтнууд болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд удирдамж болдог. Өөрөөр хэлбэл эдгээр нь хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг байна.

3.1.7.2. **Хүүхдийн төлөө зөвлөл нь** Хүүхэд хамгааллын тухай хуулийн 21.1-д заасны дагуу хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, мөн 21.2-д заасны дагуу жил бүрийн 3 дугаар улиралд багтаан хүүхэд хамгааллын тайлан гаргаж, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар төрийн захиргааны байгууллагад чиглэл өгөх, нутгийн өөрөө удирдах болон холбогдох бусад байгууллагад зөвлөмж хүргүүлэх, бодлого тодорхойлох, шийдвэр гаргах эрх бүхий оролцогч талуудад санал оруулах үүрэгтэй.

3.1.7.3. **Хүүхдийн төлөө зөвлөл нь** хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг, хүүхдийн эрхийг хамгаалах хууль, тогтоомжууд болон Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах нь тус зөвлөлийн үндсэн үүрэг юм.

3.1.7.4. Сүхбаатар аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн 2019-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүд нь хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавихад чиглээгүй байна. Харин АЗДТГ, БШУГ, ЭМГ, ХГБХХГ болон бусад холбогдох байгууллагын үндсэн чиг үүргийн ажлыг давхардуулан, тэдгээр байгууллагын хэрэгжүүлэх ёстой арга хэмжээнүүдийг төлөвлөж, зөвлөлийн үйл ажиллагааны жилийн тайланд эдгээр байгууллагын хийсэн ажлыг хэрэгжилт болгон тайлагнаж ирсэн байна. Тухайлбал:

- Сургууль, цэцэрлэг, дотуур байрны сайжруулсан ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлэх,
- ЕБС-ийн сурагчдын дунд урлаг, спортын наадмыг үе шаттай зохион байгуулах,
- Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн чуулганыг зохион байгуулж, үр дүнг тайлагнах,
- Өсвөр үеийн кабинетын үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлж, эмч мэргэжилтнүүдийг чадавхжуулах гэх мэт арга хэмжээг төлөвлөж, тайлагнасан байна.

3.1.7.5. Сүхбаатар аймгийн **Хүүхдийн төлөө зөвлөл** нь 2019-2023 онд хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүгнэлт, санал, зөвлөмж өгөх үндсэн чиг үүрэгт нийцсэн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Тодруулбал, АИТХ-ын шийдвэрээр 2023 оныг "Хүүхдийн хөгжил, хамгаалал"-ыг дэмжих жил болгон зарлаж, Аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулжээ. Мөн онцгой нөхцөл байдлын үед Хүүхдийн төлөө зөвлөлийн өргөтгөсөн хуралдааныг зохион байгуулж цаг үеийн асуудлаар үүрэг даалгаврыг өгч ажиллажээ. Харин бусад арга хэмжээнүүд нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 21.1-д заасан

хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй холбоогүй байна. Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэлт гаргахгүй байх нь хүүхдэд хамгааллын үйлчилгээний чанар, үр дүн буурахад нөлөөлнө. Иймд Сүхбаатар аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд анхаарал хандуулах шаардлагатай байна.

3.2. Гэр бүлийн орчинд архидалтаас болж хүүхэд ихээр хүчирхийлэлд өртсөн, БШУГ болон ХГБХХГ хооронд мэдээлэл солилцоо хангалтгүй, АНЭ гадны шалтгаант бэртэл, гэмтлийг 108 утсанд мэдээлдэггүй, мориноос унасан хүүхдүүдэд урьдчилан сэргийлэхээс бусад үйлчилгээг кейс нээлгүйгээр үзүүлжээ.

3.2.1 Хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн 90 гаруй хувь нь гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн бөгөөд үүний суурь шалтгаан нь архидан согтуурахтай шууд холбоотой байна.

3.2.1.1. Аймгийн ИТХ-ын 2022 оны 01 дүгээр тогтоолоор “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр”-ийг баталж, хэрэгжүүлж эхэлсэн байна. Түүнчлэн, 2023 оныг “Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих жил” болгон зарласан байна.

3.2.1.2. Хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд эцэг эх, асран хамгаалагч болон хүүхдийн асуудлаар үүрэг хүлээгчдэд сургалт, зөвлөгөө, өдөрлөг зохион байгуулж, олон улсын байгууллага, ТББ-уудтай хамтран хүүхэд, гэр бүлд чиглэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн. Гэсэн хэдий ч гэр бүлийн орчин дахь хүүхдийн хүчирхийлэл нийт хүчирхийллийн доторх эзлэх хувь өндөр хэвээр байна.

3.2.1.3. Сүхбаатар аймгийн хэмжээнд 2023 онд хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй нийт 315 хүүхдийн мэдээлэл хүүхдийн тусламжийн 108 утас болон цагдаагийн 102 утсанд ирсэн дуудлага, мэдээллээр бүртгэгдсэн байна. Эдгээрээс 307 хүүхэд буюу 97.5 хувь нь гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн байна.

3.2.1.4. Гэр бүлийн орчинд үйлдэгдсэн хүчирхийллийн ихэнх нь архидан согтуурахтай холбоотой байна. Энэ нь хүүхдийн хүчирхийллийн тоог бууруулахын тулд ахуйн архидалт, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээг багасгах, суурь шалтгааныг арилгах оновчтой, үр нөлөөтэй арга хэмжээг бүх төрийн болон хувийн байгууллагуудыг хамруулан жил бүр далайцтай хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

3.2.1.5. Ахуйн осол гэмтэлд хүүхдүүд ихээр өртдөг бөгөөд АНЭ-ийн статистикаас үзэхэд 2019-2023 онд гэрийн орчинд 212, хөдөө аж ахуйн орчинд 152 хүүхэд осол гэмтэлд оржээ. Эдгээр осол нь ихэвчлэн халуун хоол, цай, зууханд түлэгдэх, ахуйн орчинд унаж бэртэх, хөдөө аж ахуйн орчинд морь, мотоциклоос унахтай холбоотой байна. Гэр ахуй болон хөдөө аж ахуйн орчинд тохиолдож буй осол гэмтлээс хүүхдийг урьдчилан сэргийлэхэд чиглэсэн 59 арга хэмжээнд 2019-2023 онд 85.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.2.2. Хүүхдүүдийн эрсдэлийн үнэлгээний мэдээллийг БШУГ болон ХГБХХГ хооронд солилцдоггүй нь мэдээлэл хуваалцах үйл ажиллагааг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

3.2.2.1. Боловсролын салбарын сургууль, цэцэрлэгүүд хүүхэд хамгааллын бодлоготой ажилладаг бөгөөд үе тэнгийн дээрэлхэлт, багшаас үзүүлэх сэтгэл санааны дарамт, бие махбодын хүчирхийлэл зэрэгтэй холбоотой дуудлага мэдээлэл ирдэг. Тухайлбал, 2023 онд энэ төрлийн 3 дуудлага 108 утсанд бүртгэгдсэн байна.

3.2.2.2. Цагдаагийн байгууллагаас ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн бүлэг бүрийг нэг цагдаагийн албан хаагчид хариуцуулж, тухайн албан хаагч нь хариуцсан ангийн сурагчдад хяналт тавин, үе тэнгийн дээрэлхэлт болон бусад төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт, мэдээлэл хийдэг байна.

3.2.2.3. Аймгийн Засаг даргын 2023 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/112 дугаар захирамжаар хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих жилийн хүрээнд урлаг, спортын заал, танхимын үйлчилгээг үнэ төлбөргүй болгосон. Энэ арга хэмжээ нь хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд орох болон бусад төрлийн эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үр дүнтэй арга хэмжээ болсон байна.

3.2.2.4. Онцгой байдлын газраас бүх ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд эрсдэлийн үнэлгээ хийхэд, Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн багш, ажилчдын санаачилгаар цонхны порчийг багасган өөрчилж, хүүхэд унаж бэртэхээс сэргийлсэн байна. Энэ сайн жишээг бусад ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд хэрэгжүүлснээр хүүхдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах чухал үр дүнтэй ажил болсон байна.

3.2.2.5. Сүхбаатар аймгийн Бурхан шашинтны төв Эрдэнэмандал хийдийн дэргэдэх "Баян-Эрхт" шашны сургууль 2008 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд одоогоор 14 ламхай суралцаж байна. Эдгээр хүүхдүүдийн 10 нь Улаанбаатар болон бусад аймгаас, 4 нь Сүхбаатар аймгийн харьяат юм. Ерөнхий боловсролын монгол хэл, математик, эрүүл мэнд, нийгэм зэрэг 4 хичээлийг Насан туршийн боловсрол төвийн багш заадаг бол гүн ухааны хичээлийг бурхан шашны 3 багш болон Энэтхэгээс цахимаар заадаг байна.

3.2.2.6. Аймгийн Засаг даргын 2021.10.26-ны өдрийн А/612 дугаар захирамжаар Сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагддаг болон шавилан сууж буй хүүхдийн нөхцөл байдлыг тодорхойлох нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсгийг томилон ажиллуулжээ. Мөн Эрдэнэмандал хийдийн захиргаанд ХГБХХГ-ын даргын 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 267 дугаар албан бичгээр Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 03 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай чиглэлийг хүргүүлж ажилласан байна.

3.2.2.7. Сүхбаатар аймагт 14 дотуур байр ажиллаж байгаа бөгөөд "Боловсрол өргөө" нэгдсэн дотуур байр болон МСҮТ-ийн дотуур байранд хяналт шалгалт хийж, хүүхэд хамгааллын бодлоготой гэдгийг баталгаажууллаа. Гэсэн хэдий ч МСҮТ-ийн дотуур байранд 4 өрөөний хаалга түгжээгүй, эрэгтэй, эмэгтэй шүршүүр нэг дор байрласан, эцэг, эхийн уулзалтын өрөө байхгүй зэрэг зөрчил илэрсэн. Мөн барилгын их засвар хийгдээгүйгээс ариун цэврийн өрөөний суултуур эвдэрсэн, шал, хаалга хуучирсан зэрэг тулгамдсан асуудлууд байна.

3.2.2.8. Боловсрол-Өргөө нэгдсэн дотуур байрны хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд 2023 оны 12 дугаар сард хүүхдийн эрхийн улсын байцаагч хяналт шалгалт хийж, 18 заалт бүхий албан шаардлага хүргүүлж, биелэлтийг гаргуулж ажиллажээ. Мөн 2021 онд боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын асуудлаар “Хүүхэд хамгааллын баг – Анги удирдсан багшийн үүрэг, оролцоо” сэдэвт арга зүй олгох сургалтад ерөнхий боловсролын 16 сургууль, 14 дотуур байрын 439 албан хаагч, СӨБ-ын 24 байгууллагын 453 бүлгийн болон туслах багш нарыг оролцуулан зохион байгуулсан байна.

3.2.2.9. Сургууль, цэцэрлэгийн нийгмийн ажилтнууд жил бүр сурагчдын эрсдэлийн үнэлгээг ангийн багш нарын оролцоотойгоор хийж, нийгмийн орчин, сургуулийн орчин, гэр бүлийн орчин, хувийн зан чанараас шалтгаалах эрсдэлийг 37 асуултаар үнэлдэг. Сурагчдыг эрсдэлийн түвшнээр "А" (эрсдэлгүй) - "D" (өндөр эрсдэлтэй) ангилж, хагас бүтэн өнчин, үрчлэгдсэн, тавиул, хөгжлийн бэрхшээлтэй, дотуур байранд амьдардаг, хурдан морины уралдаанч, сургууль завсардаж болзошгүй зэрэг хүүхдүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг боловсролын салбарт нэгтгэдэг.

3.2.2.10. Уг судалгааны мэдээллийг Боловсрол, шинжлэх ухааны газар (БШУГ) болон Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газар (ХГБХХГ) хооронд харилцан солилцдоггүй, мэдээлэл хуваалцахгүй байгаа нь тулгамдсан асуудал болж байна. Холбогдох төрийн байгууллагууд хооронд мэдээлэл солилцоогүйгээс шалтгаалан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн мэдээллийг эрсдэлийн программд дутуу бүртгэх, хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй хүүхдүүд хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдахгүй үлдэх сөрөг нөлөөтэй байна.

3.2.3. Сүхбаатар аймагт 2023 онд боловсролын орчин, гудамж талбайд гэмтэж бэртсэн 15 хүүхдийн мэдээллийг Аймгийн нэгдсэн эмнэлэг 108 утсанд мэдээлэх үүргээ биелүүлээгүй байна.

3.2.3.1. Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой дуудлага мэдээлэл харьцангуй бага байдаг байна. Тухайлбал 2023 онд “Эмнэлгийн үйлчилгээ бүрэн авч чадахгүй байна” гэсэн дуудлага, мэдээлэл 108 утсанд ирсэн байна.

3.2.3.2. Боловсролын орчин, гудамж талбайд хүнд зодуулсан, багшдаа цохиулсан, нохойд хазуулсан, нүх рүү унасны улмаас бэртэж, гэмтсэн 15 хүүхдэд 2023 онд АНЭ-ийн яаралтай тусламж үзүүлсэн боловч эдгээр хүүхдийн мэдээллийг хүүхдийн тусламжийн 108 утсанд бүртгүүлж, мэдээлээгүй байна. Хүүхэд аливаа төрлийн хүчирхийлэл өртсөнийг анх мэдсэн төрийн албан хаагч 108 утсанд мэдээлэх үүрэгтэй боловч АНЭ-ийн яаралтай тусламжийн эмч нар энэ үүргээ хэрэгжүүлээгүй байна. Хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн мэдээлэл 108 утсанд бүртгэгдэхгүй байснаар хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг үнэлэх, дүн шинжилгээ хийх боломжгүй болох үр дагавартай байна.

3.2.4. Цахим орчны аюулгүй байдлыг сайжруулах ахиц гарч байгаа ч хяналт сул, эрсдэл өндөр хэвээр байна.

3.2.4.1. НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлыг хангахын тулд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг механизмуудыг үр дүнтэй ашиглах талаар зөвлөмж өгсөн байна.

3.2.4.2. Харилцаа холбооны зохицуулах хороо, НҮБ-ын Хүүхдийн сан, Цагдаагийн ерөнхий газар, ХГБХХГ-аас хамтран Монгол Улсын хүүхэд, гэр бүлүүдэд боловсрол, хөгжлийн мэдээлэл өгөх зорилготой ekids.mn цахим платформыг бүтээжээ. Тус платформд цахим орчинд өөрийгөө хамгаалах, цахим аюулгүй байдал, цахим орчны хүүхэд хамгаалал зэрэг сэдэвт видео контентууд багтсан бөгөөд багш сурган хүмүүжүүлэгч нар сургалтын материал хэлбэрээр ашиглах боломжтой. Мөн хүүхдийн бэлгийн хүчирхийллийн зураг, видео бичлэг, нүцгэн зураг зэрэг зөрчлийн талаар мэдээлэх талбар байршуулсан байна.

3.2.4.4. Сүхбаатар аймагт хэвлэл мэдээлэл, цахим орчинд хүчирхийлэлтэй холбоотой дуудлага, мэдээлэл харьцангуй цөөн ирдэг. Тухайлбал, 2023 онд 108 утсанд 2 хүүхэд хэвлэл мэдээлэл, цахим орчинд хүчирхийлэлд өртсөн гэх дуудлага бүртгэгдсэн байна. Дуудлага, гомдлын жишээнээс дурдвал, "Сүхбаатар аймгийн Facebook зарын группт хүүхдийн нэр төрийг гутаасан" гэх утгатай мэдээлэл ирсэн байна.

3.2.4.3. Сүүлийн үед хүүхдийн байршил тогтоох, цахим хэрэглээг хянах зорилгоор Google Family Link, Parents App зэрэг аппликейшнүүдээр дамжуулан эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдүүддээ хяналт тавих боломжууд нэмэгдэж байгаа нь ахиц дэвшил юм. Гэсэн хэдий ч эдгээр арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд зарим тулгамдсан асуудлууд байсаар байна.

3.2.4.4. Цахим орчны хэрэглээ задгай, хязгаарлалтгүй, хяналтгүй байгаагаас үүдэн хүүхдүүд янз бүрийн групп үүсгэх, тэдгээрт нэгдэх, найз нөхөдтэйгээ цаг харгалзахгүй харилцах, танихгүй хүнтэй харилцах, холбоо тогтоох, хууртагдах, зураг бичлэг явуулах, улмаар уулзах зэрэг эрсдэлтэй нөхцөл бүрдэж байна.

3.2.4.5. Цахим орчны аюулгүй байдлыг хангах ахиц гарч байгаа ч хяналт сул, эрсдэл өндөр хэвээр байна. Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газар эцэг эхэд зориулсан цахим хяналт, аюулгүй байдлын сургалтыг тогтмол зохион байгуулж, хяналтын хэрэгслийг ашиглах талаар мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх шаардлагатай.

3.2.5 Хурдан мориноос унасан 57 хүүхдийн талаар хүүхдийн тусламжийн 108 утсанд мэдээлээгүй, гэмтэл авсан 9 хүүхэд дээр кейс нээлгүйгээр үйлчилгээ үзүүлсэн байна.

3.2.5.1. Сүхбаатар аймагт хурдан морины уралдаан бусад аймагтай харьцуулахад олон удаа зохион байгуулагддаг онцлогтой бөгөөд уралдаанч хүүхэд бүрийг стандартын шаардлагад нийцсэн хувцас, хэрэглэлээр хангах, гэнэтийн ослын аюулгүйн даатгалд хамруулах шаардлагыг мөрдүүлж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилладаг байна.

3.2.5.2. Хурдан морины уралдааны үеэр хүүхдүүд унаж бэртэх тохиолдол цөөнгүй гардаг. 2023 онд зохион байгуулсан 36 уралдаанд давхардсан тоогоор 2769 морь, 2944 хүүхэд оролцсон бөгөөд 57 хүүхэд унаж, 9 нь гэмтэл бэртэл авсан байна. Даатгалын сангаас нийт 40.6 сая төгрөгийн нөхөн олговор олгожээ. Мориноос унаж нас барсан тохиолдол уралдааны явцад гараагүй ч ахуйн ослоор мориноос унаж 2 хүүхэд нас барсан тухай Цагдаагийн байгууллагын мэдээлэл байна.

3.2.5.3. Хурдан мориноос унасан 57 хүүхдийн талаар ХГБХХГ нь хүүхэд тус бүрд шаардлагатай эрүүл мэндийн болон зөвлөгөө үйлчилгээ үзүүлж ажилласан гэх боловч хүүхдийн тусламжийн 108 утсанд мэдээлээгүй, мөн гэмтэл бэртэл авсан 9 хүүхдийн хувьд кейс нээлгүйгээр үйлчилгээ үзүүлсэн байна. Эдгээр 9 хүүхдийн 5 нь уралдаанч хүүхдийн бүртгэлийн программд бүртгэлгүй, гэнэтийн ослын даатгал хийлгээгүй байна. Харин ГССҮТ-ийн нийгмийн ажилтан 2023 онд Сүхбаатар аймгийн мориноос унаж гэмтэл бэртэл авсан 3 хүүхдийн мэдээллийг 108 утсанд мэдээлсэн байна.

3.2.5.4. Засгийн газрын 2019.01.30-ны өдрийн 57 дугаар тогтоол болон аймгийн Засаг даргын 2023.01.21-ний өдрийн А/28 захирамжаар 11 дүгээр сарын 1-нээс 5 дугаар сарын 1-ний хооронд хурдан морины уралдаан, сунгаа зохион байгуулахыг хориглосон. Гэсэн хэдий ч 2023.05.06-07-ны өдрүүдэд “Жавхлант шарга-2023” болон сумдын бүсийн уралдаанууд зохион байгуулагдаж, уралдаанд бэлдэх явцад сунгаа, үсэргээ хийсэн нь дээрх тогтоол, захирамжийг зөрчсөн байна.

3.2.5.5. НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос хүүхдүүд хөдөө аж ахуй, морин уралдаан зэрэг аюултай нөхцөлд хөдөлмөр эрхэлж байгаад санаа зовниж, хурдан морины уралдаанд оролцож хүндээр гэмтсэн, амь насаа алдсан хүүхдүүдийн хэргийг мөрдөн шалгаж, буруутай этгээдүүдэд хариуцлага тооцохыг зөвлөжээ. Мөн хурдан морины уралдаан гэх мэт аюултай хөдөлмөрт хүүхдийг оролцуулдаг төрийн албан хаагчдын ашиг сонирхлын зөрчил гаргах үйлдэлд арга хэмжээ авч ажиллахыг зөвлөсөн байна.

3.2.5.6. Спортын уралдаан, тэмцээн жил бүр олон зохион байгуулагддаг бөгөөд 2023 онд спортын 18 төрлийн 65 тэмцээнд давхардсан тоогоор 3652 хүүхэд хамрагджээ. Улс, бүсийн хэмжээний тэмцээнд оролцох хүүхдүүдийг өмнө нь дасгалжуулагч багш нар хувийн унаагаар тээвэрлэдэг байсан бол 2024 онд Биеийн тамир, спортын газар хүүхэд тээврийн тусгай зориулалтын автобустай болжээ. Гэвч тус байгууллага нь хүүхэд хамгааллын бодлогогүй учир спортын үйл ажиллагааны үеийн хүүхэд хамгаалал тодорхой бус байна.

3.2.5.7. Соёл, урлагийн үйл ажиллагааны хүрээнд 2023 онд 4 төрлийн арга хэмжээнд 730 хүүхэд хамрагдсан бөгөөд Соёл, урлагийн газар нь хүүхэд хамгааллын бодлоготой ажиллаж байна. Соёл, спортын үйл ажиллагааны үеэр хүүхдийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл бүртгэгдээгүй боловч бэлтгэл, оролцооны үеэр хичээл сургалт тасалдсан тохиолдолд нөхөн хичээл орсон эсэх нь тодорхойгүй байна.

3.2.6 Сүхбаатар аймгийн ХГБХХГ нь онцгой нөхцөл байдлын үед хүүхдийг хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө, хүүхэд хамгааллын үйлчилгээний зураглалыг баталсан байна.

3.2.6.1. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам”-ын 2.9.2-т заасны дагуу онцгой нөхцөл байдлын үед хүүхдийг хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулан гаргаж ажилласан байна.

3.2.6.2. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь журмын 2.5.2-д заасны дагуу онцгой нөхцөлд хүүхдийн боловсролын үйлчилгээг тасалдуулахгүй байх үүрэгтэй. Ковид-19 цар тахлын улмаас Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 30 дугаар тогтоолоор 2020 оны 2-р сараас ерөнхий боловсролын болон их, дээд

сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоож, хичээлийг цахимаар үргэлжлүүлэх шийдвэр гарсан. Үүний дагуу сургууль, боловсролын байгууллагуудад цахим сургалт зохион байгуулахыг даалгаж, МҮОНТ-ээр теле хичээл явуулсан байна.

3.2.6.3. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам”-ын 2.9.1 дэх заалтын дагуу 2020 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн А/24 тушаалаар “Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын үйлчилгээний зураглал”-ыг баталсан байна.

3.2.6.4. Сүхбаатар аймагт 2019-2023 онд тохиолдсон нийт 323 гал түймэр, аюул ослын тохиолдлоос 251 буюу 78% нь ой хээрийн болон объектын түймэр, 40 буюу 12% нь хүчтэй салхи шуурга, аадар бороотой холбоотой байна. Мөн үер, усны ослоор энэ хугацаанд 6 дуудлага бүртгэгдэж, нийт 9 хүн амь насаа алдсаны 4 нь хүүхэд байна.

3.2.6.5. “Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих жил” нэгдсэн төлөвлөгөөний хүрээнд Баруун-Урт сумын үерийн далангийн ус зайлуулах хоолойд хамгаалалт хийх шаардлагатай 12 байршилд хамгаалах тор суурилуулж, нэг байршилд далд шугамын задгай хэсэгт 34 метр урт торон хашаа татах ажлыг гүйцэтгэсэн байна. Ингэснээр аймгийн төвийн үерийн далангийн усанд хүн эндэх эрсдэлийг бууруулжээ.

3.3. Хүчирхийлэлд өртсөн 387 хүүхдийн 87.6 хувь буюу 339 хүүхдийн мэдээллийг 108 утсанд бүртгүүлээгүй байна.

3.3.1 “Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг тайлагнах, илтгэх журам”-ын дагуу 2023 оны Сүхбаатар аймгийн хүний эрхийн төлөв байдлын тайланг аймгийн Засаг дарга нэгтгэн тайлагнасан байна.

3.3.1.1. Монгол Улс 1990 онд “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-д нэгдэж, 2017 онд хэрэгжилтийн 5-р тайланг НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд илгээсэн. Хорооны зөвлөмжид шашны сургууль, хурдан морины уралдаан, дотуур байртай холбоотой асуудлуудыг онцлон дурдсан.

- **Шашны сургууль:** Сүм хийдэд шавилан суудаг хүүхдүүдийн боловсролын хүртээмжийг сайжруулах, хүүхдийн эрхийн талаарх сургалт зохион байгуулах, гомдол мэдээлэл өгөх үр дүнтэй арга хэрэгсэл, хүүхэд хамгааллын тогтолцоог хүртээмжтэй болгох шаардлагатай гэж зөвлөсөн.
- **Хурдан морины уралдаан:** Хурдан морины уралдаанд оролцох үед гэмтсэн болон амь насаа алдсан хүүхдүүдийн хэргийг шалгаж, хариуцлага тооцохыг шаардсан. Хурдан морины уралдаан зэрэг аюултай хүүхдийн хөдөлмөрт хүүхдийг оролцуулдаг төрийн албан хаагчдын хувийн болон албаны ашиг сонирхлын зөрчилтэй үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ авахыг зөвлөсөн.
- **Дотуур байр:** Эцэг эхийн хараа хяналтаас гадуур амьдардаг хүүхдүүдийн эрхийг хамгаалах, тэдний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах, хүүхэд хамгааллын арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхийг зөвлөсөн.

3.3.1.2. “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-ийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын 5-р тайланд НҮБ-ийн Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн зөвлөмжийн холбоотой

асуудлуудаар Монгол Улсын Засаг газрын газрын хэрэг эрхлэх газрын Хүний эрхийг хангах Үндэсний хорооны тогтоолоор батлагдсан “Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг тайлагнах, илтгэх журам”-ын дагуу 2023 оны Сүхбаатар аймгийн хүний эрхийн төлөв байдлын тайланг аймгийн Засаг дарга нэгтгэн тайлагнасан байна. Тус тайланд НҮБ-ийн Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн дээрх гурван зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дотуур байрын багш нарт сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулсан, мөн арга зүйн зөвлөгөө өгсөн тухай дурдсан байна. Мөн уралдааны тоо, мориноос унасан хүүхдүүдийн тоо, тэдгээр хүүхдүүдэд олгосон гэнэтийн ослын даатгалын нөхөн төлбөрийн талаар тайлагнажээ. Гэвч шашны сургуулийн асуудлыг уг тайланд дурдаагүй байна.

3.3.2. Хүүхдийн тусламжийн 108 утас болон ХГБХХГ-ын суурин утсанд ирсэн 48 дуудлага, мэдээллийн шийдвэрлэлтийн 20.8 хувь нь торгуулийн арга хэмжээ байна.

3.3.2.1. ХГБХХГ нь 108 утасны дуудлагын дагуу хүчирхийлэл, зөрчлийн аюултай гэж үзвэл, цагдаагийн газар, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн байгууллага зэрэг холбогдох албан тушаалтнуудтай хамтран шуурхай тусламж үзүүлэх арга хэмжээг авдаг байна.

3.3.2.2. Дуудлагад үндэслэн сэргийлэх арга хэмжээг авч, шаардлагатай тохиолдолд хүүхэд, гэр бүлийн гишүүдэд сэтгэл зүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө өгдөг. Мөн тусламжийн үйлчилгээ үзүүлэхээс гадна шаардлагатай бол хамгаалах байр, нийгмийн ажилтны тусламжийг санал болгодог байна.

3.3.2.3. Сүхбаатар аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар 43 дуудлага 108 утсанд, 5 дуудлага ХГБХХГ-ын суурин утсанд, нийт 48 дуудлага, мэдээлэл ирсэн байна. Хүүхэд хүчирхийлэлд өртсөн талаар дуудлага мэдээлэл ирсэн үед дуудлагыг хүлээн авч, анхны үнэлгээ хийсний дараа аюулын түвшнийг тогтоож, шаардлагатай бол шуурхай тусламж үзүүлж, зөвлөгөө өгөх, хамгааллын арга хэмжээг шат дараалан авдаг байна. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн талаарх дуудлага, мэдээллийн шийдвэрлэлтийг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 2. Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага мэдээллийн шийдвэрлэлт 2023 он

№	Дуудлага мэдээллийн шийдвэрлэлтийн төрөл	тоо
1	Асран хамгаалагчдад хүлээлгэн өгч аюулгүй байдлыг хангасан	1
2	Асран хамгаалагчийг өөрчилсөн.	1
3	Боловсролын үйлчилгээнд хамруулсан	3
4	Гэр бүл цуцалж асран хамгаалах эрхийг ээжид өгсөн	1
5	Зөвлөгөө үйлчилгээнд хамрагдсан	3
6	Сургаалтанд хамрагдаж байгаа	1
7	Торгуулийн арга хэмжээ	10
8	Уучлалт гуйсан	3
9	Хуурамч дуудлага	2
10	Хүүхдийг хууль ёсны асран хамгаалагчдад нь хүлээлгэн өгсөн	1
11	Хүүхдэд шаардлагатай хэрэглээг олгосон	1
12	Хүүхэд асрах төвд шилжүүлсэн	1
13	Хэрэг бүртгэлийн ажиллагаа явагдаж	1
14	Хэрэг прокурорын шатанд хаагдсан	2
15	Хэрэгсэхгүй болсон	6
16	Шүүхээр шийдвэрлэсэн	7

17	Эрүүл мэндийн үйлчилгээ	4
	Нийт дүн	48

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар

3.3.2.4. Дээрх шийдвэрлэлтээс үзэхэд хүүхдийн тусламжийн 108 утас болон ХГБХХГ-ын суурин утсанд ирсэн 48 дуудлага, мэдээллийн шийдвэрлэлтийн 20.8 хувь нь торгуулийн арга хэмжээ, 12.5 хувь нь хэрэгсэхгүй болж, 14.6 хувь нь шүүхээр шийдвэрлэсэн, 36.9 хувь нь бусад үйлчилгээ байна.

3.3.2.5. “Гэмтэл, согог судлалын үндэсний төв”-ийн нийгмийн ажилтан 2023 онд Сүхбаатар аймагт хурдан мориноос унасан хүүхдийн талаар 108 утсанд 3 дуудлага мэдээлснээс 1 мэдээллийг Эрдэнэцагаан сумын хамтарсан баг давхардсан дуудлага гэж андууран, кейс нээхгүйгээр хаасан бөгөөд үүнийг ХГБХХГ-ын удирдлага, хүүхдийн эрхийн байцаагч, хүүхдийн эрх, хамгаалал хариуцсан мэргэжилтэн нар илрүүлж, хяналт тавиагүй байна. 108 утасны дуудлага, мэдээллийн шийдвэрлэлтэд тавих хяналт хангалтгүйн улмаас хүчирхийлэлд өртсөн хүүхэд шуурхай тусламжийн болон хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг авч чадахгүй байх сөрөг үр дагаврыг бий болгосон байна.

3.3.3. Хүчирхийлэлд өртсөн 387 хүүхдийн 87.6 хувь буюу 339 хүүхдийн мэдээллийг 108 утсанд бүртгүүлээгүй нь шуурхай тусламжийн болон хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг иж бүрэн үзүүлсэн гэж үзэх боломжгүй байна.

3.3.3.1. Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл нийт дуудлагын ихэнх хувийг эзэлдэг байна. Тухайлбал 2023 онд нийт 307 хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн бөгөөд ХГБХХГ-ын суурин утсанд 5, 108 утсанд 43 дуудлага мэдээлэл ирснээс 40 нь гэр бүлийн орчинд үйлдэгдсэн хүчирхийлэлтэй холбоотой байна. Цагдаагийн газрын 102 утсанд ирсэн дуудлагаас 267 хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн байна. Эдгээрээс 30 хүүхэд түр хамгаалах байранд, 30 нь зөвлөгөө мэдээлэлд, 24 нь эмнэлгийн тусламжид, 42 нь гэр бүлд эргэн нэгтгэх үйлчилгээнд, 43 нь сэтгэлзүйн үйлчилгээнд, 103 нь нийгмийн халамжид, 11 нь эрх зүйн туслалцаанд, 72 нь дэмжих болон холбон зуучлах үйлчилгээнд хамрагджээ.

3.3.3.2. Цагдаагийн газрын 102 утсанд ирсэн гэр бүлийн хүчирхийллийн дуудлагад хамаарах 267 хүүхдэд эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд түр хамгаалах байранд байрлуулах, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх зэрэг хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн ч хүүхэд тус бүр дээр кейс нээгээгүй, мөн 108 утсанд мэдээлж, бүртгүүлээгүй байна.

3.3.3.3. Насанд хүрэгчийн хамт гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн нэг айлын хүүхдүүдийн хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний хэрэгцээ нь нас, хүйс болон бусад олон хүчин зүйлээс шалтгаалан харилцан адилгүй байдаг тул хүүхэд тус бүр дээр кейс нээж, хамгааллын үйлчилгээг үзүүлэх шаардлагатай. Гэвч насанд хүрэгчтэй хамт гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, хохирогч хүүхдүүдийг хамгаалахдаа зөвхөн эх, асран хамгаалагч дээр кейс нээх байдлаар үйлчилгээ үзүүлж байгаа нь хүүхдүүдийн ялгаатай үйлчилгээ авах хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна.

3.3.3.4. Сүхбаатар аймгийн ХГБХХГ нь хүчирхийлэлд өртсөн нийт хүүхдийн харьцангуй бага хүүхдийн дуудлага, мэдээллийг 108 утсанд мэдээлдэг байна. Тухайлбал 2023 онд 108 утсанд мэдээлсэн дуудлагын тоо 48, АНЭ-ээс яаралтай тусламж авсан хүчирхийлэлд өртсөн 15 хүүхэд, хурдан мориноос унасан 57 хүүхэд, насанд хүрэгчийн хамт гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 267 хүүхэд, нийт 387 хүүхэд хүчирхийлэлд өртсөн байна. Гэтэл хүчирхийлэлд өртсөн эдгээр хүүхдийн 87.6 хувь буюу 339 хүүхдийн дуудлага, мэдээллийг 108 утсанд бүртгүүлээгүй, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлээгүй байна.

3.3.3.5. Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээллийг цагдаагийн 102 утсанд анх хүлээн авсан цагдаагийн албан хаагч хүүхдийн тусламжийн 108 утсанд тухай бүр мэдээлж ажиллах шаардлагатай. Ингэснээр гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн мэдээлэл 108 утасны мэдээллийн санд бүртгэгдэж, хүүхэд хамгааллын үйлчилгээг тухай бүр шуурхай үзүүлэх боломж бүрдэхээр байна.

3.3.3.6. Баруун-Урт сумын ЗДТГ-ын дэргэд 2023 оны 6 дугаар сард байгуулагдсан “Сэтгэл зүйн төв” иргэдэд үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлж байна. Ашиглалтад орсноос хойш 2023 онд 31, 2024 оны эхний 9 сард 110 хүнд ганцаарчилсан зөвлөгөө өгсөн бөгөөд ХГБХХГ болон Түр хамгаалах байрны хохирогчдод гэрээгээр сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлдэг байна. 2024 оны 4 сараас үйл ажиллагаа нь жигдэрч, иргэд цаг авч үйлчлүүлдэг, эргэж ирдэг болж, үр дүн нь илүү мэдэгдэхүйц болсон байна.

3.3.4 Зөрчил, гэмт хэрэгт нөлөөлж буй хүчин зүйл, шалтгаан нөхцөлийг судалгааны байгууллагаар хийлгэсэн байна.

3.3.4.1. Сүхбаатар аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь улирал тутамд дор хаяж нэг удаа хуралдах ёстой боловч 2021, 2023 онд байгууллага хоорондын мэдээлэл солилцох замаар тус бүр нэг удаа хуралджээ. 2022 онд Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо болон Хамтарсан баг хамтран уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, шинэ бүрэлдэхүүн, чиг үүрэг, шинэчлэгдсэн журмын танилцуулга, 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга зам, хамтарсан багийн үйл ажиллагаа, кейс шийдвэрлэлтийн талаар хэлэлцсэн байна.

3.3.4.2. Сүхбаатар аймагт 2019 онд шүүхээр ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүүхэд 4, 2020 онд 1, 2021 онд 5 байсан бол 2022-2023 онд хүүхэд шүүхээр ял шийтгүүлээгүй байна. Цагдаагийн газрын мэдээллээр 2019-2023 онд хүүхэд хохирсон гэмт хэрэг 172, Прокурорын газрын мэдээллээр насанд хүрээгүй хохирогч 76 хэрэг шийдвэрлэгдсэн байна. 2023 онд Хүүхдийн эрхийн улсын байцаагч нийт 8 гомдол, мэдээллийг шалгаж, 1 зөрчил хэрэгсэхгүй болгож, 7 зөрчилд 2.4 сая төгрөгийн торгууль ногдуулжээ. Тодруулбал: хориотой хугацаанд уралдаан зохион байгуулсан 5 зөрчил, асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй 3 зөрчил гарсан байна.

3.3.4.3. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн хүүхэд 2023 онд 5 байснаас 1 нь хорихоос өөр төрлийн ял шийтгэл хүлээсэн бол зөрчилд холбогдсон хүүхэд 4 байна. Мөн гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд 48 бүртгэгдсэнээс 14 нь бие махбодын хүчирхийлэл, 8 нь бэлгийн хүчирхийлэл, 13 нь сэтгэл санааны хүчирхийлэл, 13 нь үл хайхрах байдлын хохирогч болжээ. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан 4 хүүхэд холбон зуучлах, зөвлөгөө, үйлчилгээ авсан байна.

3.3.4.4. Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын албан хаагчид Баруун-Урт сумын ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдыг хариуцан авч, үе тэнгийн дээрэлхэлтийг бууруулах чиглэлээр ажиллажээ.

3.3.4.5. Сүхбаатар аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл сүүлийн 5 жилд хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- АИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны тогтоолоор "Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр"-ийг хэлэлцсэн.
- Хараат бус судалгааны хүрээлэнтэй хамтран сүүлийн 10 жилд аймагт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын судалгаа хийсэн.
- Уламжлалт зан үйлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 19 шашны байгууллагыг бүртгэж, уламжлалт бус сүм хийдийн үйл ажиллагааг тагнуулын байгууллагатай хамтран шалгах аргаар төлөвлөсөн.
- Архины зохисгүй хэрэглээтэй тэмцэх зорилгоор архины хамааралтай 25 иргэнийг сэтгэл зүйн эмчилгээнд хамруулж, 3 иргэнийг эмнэлэгт хэвтүүлэн, 8 иргэнийг "Мандах нар" АА бүлгэмд элсүүлсэн.
- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийг АИТХ-аар батлуулсан.

3.3.4.6. Сүхбаатар аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл 16, Хүүхдийн эрхийн хороо 15 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд гишүүдийн 9 нь давхцаж байна. Тодруулбал, Шүүхийн тамгын газар, Прокурор, БШУГ, ХХҮГ, Цагдаагийн газар, ШШГГ, ХГБХХГ, АИТХ-ын Нарийн бичгийн дарга нар аль алиных нь бүрэлдэхүүнд багтдаг байна.

3.3.4.7. Хүүхдийн төлөө зөвлөл нь Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэгтэй боловч гишүүдийн бүрэлдэхүүний 60 орчим хувь нь давхцаж байгаа нь өөрсдөдөө хяналт тавих боломжгүй, хяналт сулрах нөхцөл үүсгэж байна. Иймд Хүүхдийн төлөө зөвлөлийн бүрэлдэхүүнд Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдийг оруулахгүй байх зарчмыг баримтлан бүрэлдэхүүнийг шинэчлэх шаардлагатай байна.

3.3.4.8. "Хараат бус судалгааны хүрээлэн" ТББ-ын Сүхбаатар аймгийн зөрчил, гэмт хэрэгт нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаанд боловсрол, архидалт, ажилгүйдэл (амьжиргааны доройтол) зэрэг нь гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлдөг гэж дүгнэжээ. Зөвлөмжид: боловсролд хамрагдалтыг нэмэгдүүлэх, сум бүрд сургууль завсардалтын шалтгааныг судалж арилгах, архины хор уршгийн талаар сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах, АА бүлэг болон холбогдох ТББ-уудтай хамтран ажиллах, архинаас гарсан хүмүүсийн сайн туршлагыг түгээх арга хэмжээг хэрэгжүүлэхийг санал болгосон байна.

3.3.5. Хүүхдийн эрх, хамгааллын статистикийн үзүүлэлтийг нэвтрүүлэх ажил хэрэгжих шатандаа байна.

3.3.5.1. Монгол Улсын Засгийн газар нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилт болон түүнтэй холбоотой гурван нэмэлт протоколын дүгнэлт, зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж буй талаарх үндэсний тайланг НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд өргөн барих үүрэгтэй. Эдгээр тайланг үнэн зөв статистик мэдээлэлд үндэслэн, олон улсад харьцуулах боломжтой жишиг арга зүйг ашиглан боловсруулах шаардлагатай байдаг.

3.3.5.2. Хүүхдийг хүчирхийллийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх, тусламж үйлчилгээ үзүүлэх, нийгмийн бүх хүрээнд чанартай, үр дүнтэй, хүртээмжтэй хүүхэд хамгааллын үйлчилгээг хэнийг ч орхигдуулахгүйгээр үзүүлэх бодлого боловсруулахад бодит статистик мэдээлэл зайлшгүй шаардлагатай. Мөн үр дүнг үнэлэх, хяналт-шинжилгээ хийх, төсөв төлөвлөлт боловсруулахад бодит мэдээлэлд тулгуурлах нь чухал юм.

3.3.5.3. Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулиудад хүүхдийн эрх, хамгааллын талаар нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, үйл ажиллагаанд ашиглах, мөн бүртгэл, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу хөтөлж, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхийг заасан байдаг.

3.3.5.4. “Хүүхдийн эрх, хамгааллын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал” нь Үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны А/172 дугаар тушаалаар батлагдсан бөгөөд уг аргачлалд нийт 10 бүлгийн 169 үзүүлэлтийг тооцох арга зүй, мэдээллийн эх үүсвэрийг тодорхойлсон байна. Үүнд:

1. Хүүхэд хамгааллын тогтолцооны 8 үзүүлэлт
2. Хүүхдийн эрхийн ерөнхий зарчмын 6 үзүүлэлт
3. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн 11 үзүүлэлт
4. Хүүхэд хамгааллын үйлчилгээний 19 үзүүлэлт
5. Эрүүл мэндийн салбарын хүүхэд хамгааллын 41 үзүүлэлт
6. Боловсролын салбарын хүүхэд хамгааллын 41 үзүүлэлт
7. Тусгай хамгааллын арга хэмжээний 13 үзүүлэлт
8. Хүүхдийн хууль зүйн асуудалтай 15 үзүүлэлт
9. Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын 4 үзүүлэлт
10. Гамшиг, гамшгийн онцгой байдлын үеийн 5 үзүүлэлт байна.

3.3.5.5. Энэхүү аргачлал нь хүүхдийн эрх, хамгааллын статистик үзүүлэлтүүдийг тооцох, олон улсын нийтлэг арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын онцлогийг тусгасан нэгдсэн ойлголт, арга зүйн мэдээллээр статистикийн мэдээлэл гаргагч болон хэрэглэгчдийг хангах зорилготой байна.

3.3.5.6. Дээрх 10 бүлгийн 169 үзүүлэлтийн дагуу статистик мэдээлэл гаргах ажил эхний шатандаа байгаа бөгөөд бүрэн хэрэгжиж эхлээгүй байна. Гэсэн хэдий ч 1212.mn сайт дээр зарим салбарын үндсэн үйл ажиллагаатай холбоотой статистик мэдээллүүд жил бүр тогтмол нийтлэгддэг. Тухайлбал, эрүүл мэндийн салбарт хүүхэд хамгааллын чиглэлээрх 10 үзүүлэлт (нярайн эндэгдлийн түвшин, эхийн эндэгдлийн түвшин, тав хүртэлх насны өсөлтийн хоцролттой хүүхдийн эзлэх хувь зэрэг) жил бүр нийтэд мэдээлэгддэг байна.

3.3.5.7. Сүхбаатар аймагт 2023 онд хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйг сайжруулах, шүдний өвчлөлийг бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулагдсан байна. Үзлэгт 0-18 насны 23736 хүүхэд хамрагдахаар төлөвлөснөөс 17035 хүүхэд буюу 71% нь хамрагдсан байна. Үүний дотор 2-17 насны 14535 хүүхдийн 11628 буюу 80% нь шүд цоорох өвчтэй гэж тогтоогджээ.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/478 дугаар захирамжаар 100 сая төгрөгийн санхүүжилтээр хувийн хэвшлийн "Аман хужир" болон "Цагаан-Алт" эмнэлгүүдтэй гэрээ байгуулж, нийт 1250 хүүхдийг эмчилгээнд хамруулахаар төлөвлөснөөс 978 хүүхэд буюу 73% нь эмчилгээнд хамрагджээ. Нийт 14464 хүүхэд шүдний нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдсан байна. Эдгээр тоо мэдээлэл нь хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн байдалд анхаарал хандуулж, үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

---oOo---

Холбогдох байгууллагын санал:



**СҮХБААТАР АЙМГИЙН
ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ,
ХАМГААЛЛЫН ГАЗАР**

Ахмадын-3 гудамж, 1 дүгээр баг, Баруун-Урт сум,
Сүхбаатар аймаг 22087 Утас:70518402
Цахим шуудан: sukhbaatar@cfga.gov.mn

2024.11.01

№ 158

танай

-ны №

-т

Г Санал хүргүүлэх тухай Г

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тус газар нь Монгол улсын төрөөс хүүхдийн чиглэлээр баримтлаж буй хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хүрээнд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байгаа бөгөөд орон нутагтаа салбарын хэмжээнд мөрдөгдөж буй 58 хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, аймгийн Засаг даргатай жил бүр үр дүнгийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан ажиллаж гэрээнд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, тайлант хугацаанд тогтмол 90% – 93,1%-тай үнэлэгдэж байсан.

Эрсдэлийн үнэлгээний программын хөгжүүлэлтийг сайжруулж салбарын хэмжээнд эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийн эрсдэлийг үнэлэх нэгдсэн аргачлалтай болох;

Улсын хэмжээнд хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд оролцогч талуудын дундын мэдээллийн нэгдсэн санг бий болгох;

Хүний нөөцийн тогтвор суурьшилтай ажиллуулах бодлогын хүрээнд нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлах, зарцуулах хөрөнгийн асуудлыг төсөвт тусгаж шийдвэрлэх;

Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалыг боловруулах;

Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх зардлыг нэмэгдүүлэх; төсвийн зардлыг бүлэг хооронд нь гүйлгээнд захиран зарцуулах эрхийг олгодог байх;

Цаашид гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах болно.

ДАРГА



М.ТУУЛ

2224070050

Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:

Сүхбаатар аймгийн ХГБХХГ-аас ирүүлсэн албан бичигт хүүхэд хамгааллын үйл ажиллагаатай холбоотой 5 санал дурдсан бөгөөд цаашид аудитаар өгсөн зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахаа илэрхийлсэн байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Хүүхдийн хөгжил, хамгааллын үйл ажиллагаа нь хүүхдийн амьдралын нөхцөл байдал, эрсдэл, нийгмийн бүлгийн онцлог, насны ялгаа зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг боловч хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрүүд нь хүлээн авагчдын онцлогт тохироогүй байна.
2. Хүүхэд хамгааллын дундын мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй, мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч дутагдалтай, Хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавихад чиглэсэн арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.
3. Гэр бүлийн орчинд нийт хүчирхийллийн 97.5 хувь нь үйлдэгдэж байхад хүүхэд хамгааллын төсвийн зөвхөн 16.9 хувийг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан байна.
4. Хүүхэд хамгааллын зардлын 3.1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, эрсдэлт хүүхдүүдийг дутуу бүртгэснээс урьдчилан сэргийлэх үйлчилгээнд бүрэн хамруулаагүй байна.
5. Гэр бүлийн орчинд архидалтаас болж хүүхэд ихээр хүчирхийлэлд өртсөн, БШУГ болон ХГБХХГ хооронд мэдээлэл солилцоо хангалтгүй, АНЭ гадны шалтгаант бэртэл, гэмтлийг 108 утсанд мэдээлдэггүй, мориноос унасан хүүхдүүдэд урьдчилан сэргийлэхээс бусад үйлчилгээг кейс нээлгүйгээр үзүүлжээ.
6. Хүчирхийлэлд өртсөн 387 хүүхдийн 87.6 хувь буюу 339 хүүхдийн мэдээллийг 108 утсанд бүртгүүлээгүй нь хүүхэд хамгааллын үйлчилгээнд цахимаар хяналт тавих боломжгүй болох сөрөг үр дагавартай бөгөөд насанд хүрэгчтэй хамт гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, хохирогч хүүхдүүдийн хувьд зөвхөн эх, асран хамгаалагч дээр кейс нээх байдлаар үйлчилгээ үзүүлж байгаа нь хүүхдүүдийн ялгаатай үйлчилгээ авах хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитаар өгсөн дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Сүхбаатар аймгийн Засаг дарга /Хүүхдийн төлөө зөвлөлийн дарга/-д:

1. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдтэй давхардаж байгаа тул тус зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчилж, зөвлөлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой арга хэмжээг тусгаж, хэрэгжүүлж байх.

Сүхбаатар аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт:

1. Хүүхдийн төлөө зөвлөлийн ажлын албаны чиг үүргийн дагуу хүүхэд хамгааллын холбогдох хууль тогтоомж, хөтөлбөр, конвенц, НҮБ-ийн Хүүхдийн эрхийн хороо болон бусад олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмж зэрэг хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавихад чиглэсэн арга хэмжээг судалж, Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааны жил бүрийн төлөвлөгөөнд тусгуулах, хэрэгжилтийг тайлагнаж байх.
2. Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, жил бүр Хүүхдийн төлөө зөвлөлд танилцуулж байх, хамгаалах, нөхөн сэргээх болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулах.
3. Насанд хүрэгчийн хамт гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд; хүчирхийллийн улмаас болон олон нийтийн газар бэртэж, гэмтсэний улмаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан хүүхдүүд; хурдан морины уралдаанд мориноос унасан, бэртсэн хүүхдүүдийн мэдээллийг 108 утсанд бүртгүүлж, шуурхай тусламжийн болон хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг (кейс нээж) үзүүлэх талаар **хамтарсан багт** арга зүйн зөвлөмж, чиглэл хүргүүлж, хяналт тавьж ажиллах.
4. Үйл ажиллагааны статистик тоо мэдээг батлагдсан маягтын дагуу бүрэн гаргаж, хадгаламжийн нэгж болгон архивлах, нөхцөл байдлын үнэлгээ, хувийн хэргийн хадгаламжийн нэгжийг архивын шаардлагад нийцүүлэх.
5. Шашны сургуулийн хүүхдүүдийн мэдээллийг тогтмол хугацаанд гаргуулан авч, хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд хяналт тавьж, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгч, хамтран ажиллах.
6. БШУГ, ЭМГ, ХХҮГ, НДГ болон холбогдох бусад төрийн байгууллагуудаас эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн мэдээллийг тодорхой хугацааны давтамжтайгаар авч, дүн шинжилгээ хийн, улмаар эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн программд оруулж, мэдээллийн санг шинэчлэх ажлыг тогтмол хугацаанд зохион байгуулах.

---oOo---



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/76


Баруун-Урт сум

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар, аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хүргүүлж ажиллахыг ахлах аудитор (Н.Болдбаатар)-д үүрэг болгосугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2024 оны 11 дүгээр сарын 30, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор тус тус Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хүүхдийн төлөө зөвлөлийн дарга (М.Идэрбат), Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга (М.Туул)-т үүрэг болгосугай.
4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Н.Болдбаатар), аудитор (Э.Алтансүх), аудитор (Б.Ганцэцэг) нарт үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аудитын менежер (М.Нарантуяа)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

D:/Bichig hereg/2024/tushaal